

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭД
ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, САНАА БОДОЛ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2021



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



ОЮУНЫ ХӨГЖЛИЙН
ИНСТИТУТ

Энэхүү судалгааг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Оюуны хөгжлийн институт” ТББ-ын судлаачдын баг гүйцэтгэв. Уг судалгааны мэдээлэл нь захиалагч байгууллагын үзэл бодол, байр суурийг илэрхийлэхгүй бөгөөд судалгааны багийн дүгнэлт болно.

АГУУЛГА

| | |
|---|----|
| ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ | 1 |
| ГРАФИКИЙН ЖАГСААЛТ | 2 |
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ | 3 |
| Судалгааны үр дүнгийн хураангуй | 5 |
| СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ | 10 |
| Судалгааны үндэслэл, зорилго | 10 |
| Судалгааны хамрах хүрээ..... | 10 |
| Судалгааны зорилго, судлах зүйл/ судалгааны үндсэн асуулт..... | 10 |
| Судалгааны арга зүй, аргачлал | 11 |
| Судалгааны мэдээлэл цуглуулах арга | 11 |
| Судалгааны түүвэр..... | 12 |
| БҮЛЭГ 1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 14 |
| БҮЛЭГ 2. УИХ-ЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН САНАА БОДОЛ, ҮНЭЛГЭЭ..... | 21 |
| БҮЛЭГ 3. УИХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ХЭЛБЭР .. | 29 |
| ДҮГНЭЛТ | 33 |
| САНАЛ ЗӨВЛӨМЖ | 35 |
| ХАВСРАЛТ | 38 |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| Хүснэгт 1. Түүврийн бүтэц..... | 12 |
| Хүснэгт 2. Судалгааны нарийвчилсан түүвэр | 13 |
| Хүснэгт 3. УИХ-ын албан ёсны веб сайтыг талаар мэддэг эсэх, боловсролоор | 15 |
| Хүснэгт 4 Хуулийн төсөлд иргэдийн саналыг тусгах Lawforum.parliament.mn талбарыг ашиглаж байсан эсэх, байрилаар | 15 |
| Хүснэгт 5 УИХ-ын үйл ажиллагааны талаар сонирхдог байдал, хөдөлмөр эрхлэлтээр | 16 |
| Хүснэгт 6 УИХ-ын үйл ажиллагааны талаар сонирхдог байдал, гэр бүлийн байдлаар | 17 |
| Хүснэгт 7 Хуулийн төсөлд санал өгөх, хууль боловсруулах үйл ажиллагаанд оролцох боломж. Дундаж утгууд. (1-огт хангалтгүй, 10-бүрэн хангалттай) | 17 |
| Хүснэгт 8. УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаар мэдлэг ойлголт, хүйсээр..... | 19 |
| Хүснэгт 9. УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаар мэдлэг ойлголт, боловсролоор | 19 |
| Хүснэгт 10. УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаар мэдлэг ойлголт, байрилаар | 20 |
| Хүснэгт 11. УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаар мэдлэг ойлголт, гэр бүлийн байдлаар | 20 |
| Хүснэгт 12 УИХ-ын үйл ажиллагааны талаарх үнэлгээ, орлогоор..... | 22 |
| Хүснэгт 13 УИХ-ын үйл ажиллагаанд өгөх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, байрилаар . | 22 |
| Хүснэгт 14 Иргэдийн үнэлгээ, насны бүлгээр | 23 |
| Хүснэгт 15. Иргэн бүр сонгосон гишүүнээрээ дамжуулан хууль боловсруулах үйл ажиллагаанд саналаа өгөх, оролцох боломжтой эсэх үнэлгээ, бүсээр..... | 24 |
| Хүснэгт 16. УИХ-ын үйл ажиллагааны хүртээмжтэй байдлын үнэлгээ | 25 |
| Хүснэгт 17. УИХ-ын гишүүд хууль санаачлах эрхээ үр нөлөөтэй гүйцэтгэдэг байдалд өгсөн үнэлгээ..... | 26 |
| Хүснэгт 18 УИХ-аас баталсан хууль, тогтоол биелэгддэг гэж үздэг байдал, боловсролын төвшинөөр..... | 27 |
| Хүснэгт 19 УИХ-аас баталсан хууль, тогтоолын биелэлтийг орлоготой харьцуулбал | 27 |
| Хүснэгт 20. УИХ-ын үйл ажиллагааны талаар үнэлгээ хөдөлмөр эрхлэлтийн байдлаар..... | 27 |
| Хүснэгт 21 Иргэдийн сонгосон төлөөлөгчидтэйгөө харьцаж буй оролцооны хэлбэрүүд, насны бүлгээр..... | 30 |
| Хүснэгт 22 Иргэдийн хувьд хуулийн төсөлд саналаа өгөх боломжууд, иргэдийн оршин суугаа бүсчлэлээр | 31 |

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| График 1. Иргэд www.parliament.mn сайтын талаар мэддэг эсэх | 14 |
| График 2 Судалгаанд оролцогчдын УИХ-ын үйл ажиллагааны талаар сонирхдог байдал | 15 |
| График 3 УИХ-ын бүтэц, үйл ажиллагаануудын талаарх иргэдийн мэдлэг ойлголт | 18 |
| График 4. Судалгаанд оролцогчдын УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаар мэдлэг ойлголт... | 18 |
| График 5 УИХ-ын үйл ажиллагааны өөрчлөлтийг үнэлэх үнэлгээ | 21 |
| График 6 УИХ-ийн үйл ажиллагаа сайжирч байгаа эсэх, насны бүлгээр..... | 21 |
| График 7. УИХ-ын үйл ажиллагаанд өгөх иргэдийн дундаж үнэлгээ, хүйсээр /1-10 оноо/ | 22 |
| График 8. УИХ-ын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ, байриллаар /1-5 оноо/..... | 23 |
| График 9. УИХ-ын үйл ажиллагааны хүртээмжтэй байдлын үнэлгээ, байриллаар..... | 25 |
| График 10. УИХ-ын үйл ажиллагааг үнэлэх сэтгэл ханамж, насны бүлгээр /1-10 оноогоор/.... | 25 |
| График 11. УИХ-ын гишүүдийн хариуцлагад өгөх үнэлгээ, насны бүлгээр /1-10 оноогоор/ | 26 |
| График 12. УИХ-аас баталсан хууль, тогтоол хэр зэрэг биелэгддэг вэ? | 26 |
| График 13. Та УИХ-ын үйл ажиллагаанд хэр сэтгэл ханамжтай байдаг вэ? | 28 |
| График 14 Иргэд хуулийн төсөлд саналаа өгөх, хууль боловсруулах үйл ажиллагаанд оролцох боломжтой байдал, насны бүлгээр..... | 29 |
| График 15 Иргэдийн сонгосон төлөөлөгчидтэйгөө харьцаж буй оролцооны хэлбэрүүд | 30 |
| График 16 Иргэдийн сонгосон төлөөлөгчидтэйгөө харьцахыг хүсэж буй оролцооны хэлбэрүүд | 31 |
| График 17 Судалгаанд оролцсон иргэдийн lawforum.parliament.mn сайтыг хэрэглэдэг байдал . | 32 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--------------|---|
| ЗГ | <i>Засгийн газар</i> |
| ИТХ | <i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i> |
| МУ | <i>Монгол улс</i> |
| УИХ | <i>Улсын Их Хурал</i> |
| УИХТГ | <i>Улсын Их Хурлын Тамгын газар</i> |
| САТИ | <i>Computer-assisted telephone interviewing</i> |
| КАР | <i>Knowledge Attitude Practice</i> |

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн хүрэхээр төлөвлөж буй нэг үр дүн нь Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, оролцооны хэлбэрт тохирсон арга хэрэгслийг боловсронгуй болгох, парламентын үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмжийг сайжруулахад оршино.

Энэхүү үр дүнгийн суурь үзүүлэлтийн түвшинг тодорхойлох зорилгоор Улсын Их Хурал, түүний хууль тогтоох үйл ажиллагааны талаарх иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэг, санаа бодлыг тандан судлах судалгааг “төслийн суурь судалгаа” болгон явууллаа. Энэхүү үзэл баримтлалын хүрээнд хараат бус, хөндлөнгийн байр сууринаас судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Судалгааны тайлан нийт 3 бүлгээс бүрдэх бөгөөд бүлэг тус бүрд судалгааны асуултуудыг дараах байдлаар хувааж оруулсан.

Бүлэг 1. УИХ-ын үйл ажиллагааны талаарх иргэдийн мэдлэг, ойлголт

1. Та Улсын Их Хурал (цаашид “УИХ” гэх)-ын үйл ажиллагааны талаар хэр зэрэг сонирхдог вэ?
2. Та УИХ-ын үйл ажиллагааны талаарх өөрийн мэдлэгийг үнэлнэ үү. Маш сайн мэдэх үү, сайн мэдэх үү, дунд зэрэг мэдэх үү, бага зэрэг мэдэх үү, огт мэдэхгүй юу?
3. Дараах хариултуудаас аль нь УИХ-ын үндсэн чиг үүрэгт хамаарах вэ? /олон сонголттой/

Бүлэг 2. УИХ-ын талаарх иргэдийн санаа бодол, үнэлгээ

1. УИХ-ын үүрэг хариуцлагын талаар дараах асуултуудтай Та хэр санал нийлэх вэ? Та дараах өгүүлбэрүүдтэй хэр зэрэг санал нийлэх вэ? Бүрэн санал нийлэх үү, ер нь санал нийлэх үү, зарим талаар санал нийлэх үү, эсвэл ер нь санал нийлэхгүй, огт санал нийлэхгүй юу?
2. Та УИХ-ын гишүүдийн хариуцлагыг хэрхэн үнэлэх вэ? 1-10 хүртэлх оноогоор үнэлнэ үү. (1-огт хангалтгүй, 10-бүрэн хангалттай)
3. УИХ-ын үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн үнэлэх вэ? Та дараах өгүүлбэрүүдтэй хэр зэрэг санал нийлэх вэ? Бүрэн санал нийлэх үү, ер нь санал нийлэх үү, зарим талаар санал нийлэх үү, эсвэл ер нь санал нийлэхгүй, огт санал нийлэхгүй юу?
4. Та УИХ-ын албан ёсны цахим хуудас (веб сайт)-ыг мэдэх үү?
5. Та УИХ-аас баталсан хууль, тогтоол хэр зэрэг биелэгддэг гэж бодож байна вэ?
6. Таны бодлоор УИХ-ын үйл ажиллагаа ерөнхийдөө ямар байна вэ?
7. Та УИХ-ын үйл ажиллагаанд хэр сэтгэл ханамжтай байдаг вэ? 1-10 хүртэлх оноогоор үнэлнэ үү. (1-огт хангалтгүй, 10-бүрэн хангалттай)

Бүлэг 3. УИХ-ын үйл ажиллагаанд дах иргэдийн оролцоо, хэлбэр

1. Та УИХ-ын дараах үйл ажиллагаанд хэр зэрэг ач холбогдол өгч, сонирхдог вэ?

2. Хуулийн төсөлд иргэд саналаа өгөх, хууль боловсруулах үйл ажиллагаанд оролцох боломжтой байдаг уу? 1-10 хүртэлх оноогоор үнэлнэ үү. (1-огт хангалтгүй, 10-бүрэн хангалттай)
3. Та хуулийн төсөлд иргэдийн саналыг тусгах Lawforum.parliament.mn талбарыг ашиглаж байсан уу?
4. Та хуулийн төсөлд саналаа ямар байдлаар өгөх хүсэлтэй байна вэ? /олон сонголттой/
5. Та өөрийн сонгосон төлөөлөлтэйгөө (УИХ-ын гишүүн) ямар хэлбэрээр харилцдаг вэ? /олон сонголттой/
6. Бэлчээрийн асуудлаар иргэд орон нутгийн хуралтай хамтран ажилладаг уу?
7. Бэлчээрийн асуудлаар орон нутгийн байгууллага иргэдтэй хэрхэн хамтран ажилладаг вэ?
8. Бэлчээрийн асуудлаар иргэд орон нутгийн хамтын ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг уу? 1-10 хүртэлх оноогоор үнэлнэ үү. (1-огт хангалтгүй, 10-бүрэн хангалттай)

Судалгааны үр дүнгийн хураангуй

Судалгааны хүрээнд бид Улаанбаатар хот, болон 21 аймгаас төлөвлөгөөний дагуу 2000 хүний түүвэртэй судалгааны мэдээлэл цуглуулалт хийлээ.

| № | Ангилал | Оролцогчдын тоо | |
|---|--------------------|--------------------------------|--------|
| 1 | Насны бүлэг | 18 хүртэлх нас | n=6 |
| | | 18-35 нас | n=829 |
| | | 36-55 нас | n=847 |
| | | 56-аас дээш нас | n=318 |
| 2 | Хүйс | Эрэгтэй | n=933 |
| | | Эмэгтэй | n=1065 |
| | | Бусад | n=2 |
| 3 | Боловсролын түвшин | Бүрэн бус дунд ба түүнээс доош | n=189 |
| | | Бүрэн дунд, тусгай дунд | n=692 |
| | | Дээд | n=1119 |
| 4 | Байршил | Улаанбаатар | n=952 |
| | | Баруун бүс | n=242 |
| | | Хангайн бүс | n=284 |
| | | Төвийн бүс | n=340 |
| | | Зүүн бүс | n=182 |

*1-10 хүртэлх тоогоор үнэлсэн бөгөөд 1-рүү ойртох тусам огт хангалтгүй 10-т ойртох тусам бүрэн хангалттай гэсэн утгыг илэрхийлнэ.

“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтийн ойлголт, санаа бодол” судалгааны тайлан

| № | Үнэлгээ | Дундаж үнэлгээ |
|---|--|----------------|
| 1 | Иргэдээс УИХ-ын гишүүдийн хариуцлагад өгч буй үнэлгээ (1-огт хангалтгүй, 10-бүрэн хангалттай) | 4.22 |
| 2 | Хуулийн төсөлд иргэд саналаа өгөх, хууль боловсруулах үйл ажиллагаанд оролцох боломжтой эсэх үнэлгээ (1-огт боломжгүй, 10-бүрэн боломжтой) | 4.12 |
| 3 | УИХ-ын үйл ажиллагаанд өгөх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ (1-огт хангалтгүй, 10-бүрэн хангалттай) | 4.56 |
| 4 | Бэлчээрийн асуудлаар иргэд орон нутгийн хамтын ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг эсэх (1-огт хангалтгүй, 10-бүрэн хангалттай) | 4.78 |

| № | Судалгааны онцлох үзүүлэлтүүдийн хураангуй | Хувь |
|---|--|-------|
| 1 | Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаар сонирхдог оролцогчид | 36.6% |
| 2 | УИХ-ын үйл ажиллагааг сайжирч байна гэж үнэлсэн оролцогчид | 20.3% |
| 3 | УИХ-ын албан ёсны веб сайт www.parliament.mn -ыг мэддэг | 6.8% |
| 4 | Улсын төсөв хэлэлцэн батлах үйл явцад ач холбогдол өгдөг | 30.9% |

| № | Судалгааны онцлох үзүүлэлтүүдийн хураангуй (Уг үзүүлэлтүүдийг 1-5 оноогоор үнэлсэн. 5-хамгийн өндөр 1-хамгийн бага утга) | Үнэлгээ |
|---|---|---------|
| 1 | УИХ-ын хууль санаачлан, хэлэлцэн батлах үйл явцын талаарх мэдлэг | 2.83 |
| 2 | УИХ-аас гүйцэтгэх засаглалд тавих хяналтын үйл ажиллагааны талаарх мэдлэг | 2.56 |
| 3 | Байнгын хороо болон түр хорооны үйл ажиллагааны талаарх мэдлэг | 2.43 |
| 4 | УИХ-ын бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдлэг | 2.68 |
| 5 | УИХ-ын гишүүд хууль санаачлах эрхээ үр нөлөөтэй гүйцэтгэдэг | 2.65 |
| 6 | УИХ-нь засгийн газарт хяналт тавьж ажиллаж чаддаг | 2.63 |
| 7 | УИХ нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хангах чиглэлд анхаарч ажиллаж чаддаг | 2.59 |
| 8 | УИХ дахь сөрөг хүчний төлөөллүүд үр дүнтэй ажиллаж чаддаг | 2.45 |

Судалгааны хүрээнд Улсын Их Хурлын талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг тодорхойлох дараах үзүүлэлтүүдийг хэмжсэн. Үзүүлэлт тус бүрийг 1-5 оноогоор үнэлүүлсэн бөгөөд 1 оноо нь УИХ-ын эдгээр үйл ажиллагааны талаар огт мэдэхгүй, 5

“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтийн ойлголт, санаа бодол” судалгааны тайлан

оноо нь УИХ-ын үйл ажиллагааны талаар маш сайн мэднэ гэсэн утгыг илэрхийлнэ. Доорх хүснэгтүүдэд өсвөр үе залуучуудыг 18 хүртэлх насны хүүхдүүд болон 18-аас 35 насны залуучууд гэж ангилж УИХ-ын талаарх мэдлэг ойлголтын дундаж оноог тооцож гаргасан бөгөөд судалгаанд оролцогчдын байрилыг Улаанбаатар хот, аймгийн төв болон сумуудаар ангилж алслагдсан бус нутгийн иргэдийн мэдлэг ойлголтын дунджийг гаргалаа.

Мөн судалгаанд оролцогчдын хүйс, гэр бүлийн байдал, орлогын төвшинөөр нь УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдлэг ойлголтыг харьцуулж орууллаа. Түүнчлэн судалгаанд оролцогчдын УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдлэг ойлголтын ерөнхий дундаж дүнг орууллаа.

Насны ангиллаар

| № | Асуултууд | Нас | |
|---|---|----------|-----------|
| | | Өсвөр үе | Залуучууд |
| 1 | УИХ-ын хууль санаачлан, хэлэлцэн батлах үйл явцын талаар иргэдийн мэдлэг | 2.33 | 2.77 |
| 2 | УИХ-аас гүйцэтгэх засаглалд тавих хяналтын үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.00 | 2.57 |
| 3 | УИХ-аас хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын талаар иргэдийн мэдлэг | 2.43 | 2.56 |
| 4 | Байнгын хороо болон түр хорооны үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.00 | 2.45 |
| 5 | УИХ-ын бүтэц, зохион байгуулалтын талаар иргэдийн мэдлэг | 2.52 | 2.67 |
| 6 | УИХ дахь намын бүлгийн үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.48 | 2.50 |

Байршлаар

| № | Асуултууд | Байршил | | |
|---|---|-------------|-------|------|
| | | Улаанбаатар | Аймаг | Сум |
| 1 | УИХ-ын хууль санаачлан, хэлэлцэн батлах үйл явцын талаар иргэдийн мэдлэг | 2.75 | 2.85 | 2.93 |
| 2 | УИХ-аас гүйцэтгэх засаглалд тавих хяналтын үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.48 | 2.61 | 2.67 |
| 3 | УИХ-аас хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын талаар иргэдийн мэдлэг | 2.42 | 2.56 | 2.65 |
| 4 | Байнгын хороо болон түр хорооны үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.36 | 2.45 | 2.55 |
| 5 | УИХ-ын бүтэц, зохион байгуулалтын талаар иргэдийн мэдлэг | 2.62 | 2.71 | 2.77 |
| 6 | УИХ дахь намын бүлгийн үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.42 | 2.59 | 2.68 |

Орлогоор

| № | Асуултууд | Орлого | | | | |
|---|--|--------------------------|-----------------------|----------------------|----------------|-----------------------|
| | | 300 мянган төгрөг хүртэл | 300-500 мянган төгрөг | 500.000-1 сая төгрөг | 1-2 сая төгрөг | 2-оос дээш сая төгрөг |
| 1 | УИХ-ын хууль санаачлан, хэлэлцэн батлах үйл явцын талаар иргэдийн мэдлэг | 2.59 | 2.83 | 3.00 | 3.01 | 2.94 |

“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтийн ойлголт, санаа бодол” судалгааны тайлан

| | | | | | | |
|---|---|------|------|------|------|------|
| 2 | УИХ-аас гүйцэтгэх засаглалд тавих хяналтын үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.36 | 2.54 | 2.74 | 2.76 | 2.59 |
| 3 | УИХ-аас хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын талаар иргэдийн мэдлэг | 2.32 | 2.52 | 2.68 | 2.72 | 2.57 |
| 4 | Байнгын хороо болон түр хорооны үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.23 | 2.40 | 2.66 | 2.60 | 2.29 |
| 5 | УИХ-ын бүтэц, зохион байгуулалтын талаар иргэдийн мэдлэг | 2.56 | 2.67 | 2.85 | 2.97 | 2.60 |
| 6 | УИХ дахь намын бүлгийн үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.39 | 2.57 | 2.72 | 2.69 | 2.33 |

Хүйсээр

| № | Асуултууд | Хүйс | |
|---|---|---------|---------|
| | | Эрэгтэй | Эмэгтэй |
| 1 | УИХ-ын хууль санаачлан, хэлэлцэн батлах үйл явцын талаар иргэдийн мэдлэг | 2.94 | 2.74 |
| 2 | УИХ-аас гүйцэтгэх засаглалд тавих хяналтын үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.67 | 2.48 |
| 3 | УИХ-аас хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын талаар иргэдийн мэдлэг | 2.59 | 2.46 |
| 4 | Байнгын хороо болон түр хорооны үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.54 | 2.35 |
| 5 | УИХ-ын бүтэц, зохион байгуулалтын талаар иргэдийн мэдлэг | 2.79 | 2.59 |
| 6 | УИХ дахь намын бүлгийн үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.63 | 2.46 |

Гэр бүлийн байдлаар

| № | Асуултууд | Гэр бүлийн байдал | | | |
|---|---|-------------------|-----------|----------------|----------|
| | | Гэрлэсэн | Гэрлээгүй | Өрх толгойлсон | Бэлэвсэн |
| 1 | УИХ-ын хууль санаачлан, хэлэлцэн батлах үйл явцын талаар иргэдийн мэдлэг | 2.88 | 2.67 | 2.70 | 2.66 |
| 2 | УИХ-аас гүйцэтгэх засаглалд тавих хяналтын үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.62 | 2.43 | 2.44 | 2.22 |
| 3 | УИХ-аас хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын талаар иргэдийн мэдлэг | 2.56 | 2.47 | 2.37 | 2.29 |
| 4 | Байнгын хороо болон түр хорооны үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.48 | 2.34 | 2.30 | 2.20 |
| 5 | УИХ-ын бүтэц, зохион байгуулалтын талаар иргэдийн мэдлэг | 2.73 | 2.61 | 2.52 | 2.29 |
| 6 | УИХ дахь намын бүлгийн үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.60 | 2.41 | 2.34 | 2.20 |

“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтийн ойлголт, санаа бодол” судалгааны тайлан

Нэгдсэн дундаж

| № | Асуултууд | Ерөнхий дундаж | Хувиар |
|----------|---|-----------------------|---------------|
| 1 | УИХ-ын хууль санаачлан, хэлэлцэн батлах үйл явцын талаар иргэдийн мэдлэг | 2.83 | 56.6 |
| 2 | УИХ-аас гүйцэтгэх засаглалд тавих хяналтын үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.57 | 51.3 |
| 3 | УИХ-аас хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын талаар иргэдийн мэдлэг | 2.52 | 50.4 |
| 4 | Байнгын хороо болон түр хорооны үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.44 | 48.7 |
| 5 | УИХ-ын бүтэц, зохион байгуулалтын талаар иргэдийн мэдлэг | 2.69 | 53.7 |
| 6 | УИХ дахь намын бүлгийн үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг | 2.54 | 50.7 |

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны үндэслэл, зорилго

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн хүрэхээр төлөвлөж буй нэг үр дүн нь Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, оролцооны хэлбэрт тохирсон арга хэрэгслийг боловсронгуй болгох, парламентын үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмжийг сайжруулахад энэхүү төслийн оршино. Төслийн үр дүнгийн суурь үзүүлэлтийн түвшинг тодорхойлох зорилгоор Улсын Их Хурал, түүний хууль тогтоох үйл ажиллагааны талаарх иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэг, санаа бодлыг тандан судлах судалгааг “төслийн суурь судалгаа” болгон гүйцэтгэлээ.

Судалгааны хамрах хүрээ

Судалгаа нь үндэсний хэмжээнд хийгдсэн бөгөөд нийгмийн олон талт бүлгүүдийн төлөөллийг тусгасан. Үүнд:

- Алслагдсан бүс нутгийн оршин суугчид;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд;
- 15-17 насны хүүхэд, залуучууд;
- Өрх толгойлсон эцэг эхчүүд.

Судалгааны зорилго, судлах зүйл/судалгааны үндсэн асуулт

Энэхүү судалгаа нь дараах гол асуултуудад хариулах зорилттой.

1. Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагааны талаарх иргэд, олон нийтийн /судалгаанд хамрагдагчид/ мэдээлэл, мэдлэг ямар хэмжээнд байна вэ?
2. Монгол Улсын Их Хурлын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтын талаар иргэд хэр зэрэг ойлголт, мэдлэгтэй байна вэ? Тэд Улсын Их Хурал, түүний үйл ажиллагаа, Улсын Их Хурлын гишүүдийн үүрэг хариуцлагын талаар илүү ихийг мэдэхийг хүсэж байна уу?
3. Иргэд Улсын Их Хурлын шийдвэр гаргах, улсын төсөв боловсруулах, хэлэлцэн батлахад хэр зэрэг ач холбогдол өгч оролцдог вэ?
4. Улсын Их Хурал, түүний хууль тогтоох үйл ажиллагааны ил тод байдлын талаар ойлголт, мэдлэг ямар түвшинд байна вэ?
5. Боловсруулж буй болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд санал авах цахим систем (Lawmaker, Lawforum)-ийн талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл хэр байна вэ?
6. Улсын Их Хурлаас батлан гаргаж буй хууль, бусад шийдвэрийн талаар иргэд хэр зэрэг ойлголт, мэдлэг, мэдээлэлтэй байдаг вэ? Иргэд хэрхэн, яаж мэдээлэл авахыг хүсэж байна вэ? Оролцооны ямар хэлбэрийг иргэд түлхүү ашиглахыг дэмжиж байна вэ?

7. Иргэд өөрийн сонгосон төлөөлөгч өөрсдийн болон олон нийтийн асуудлыг шийдвэрлэхэд тусалж, өөрчлөлт оруулах боломжтой гэдэгт итгэдэг үү? Тэд сонгосон төлөөлөгчидтэйгөө ямар харилцаатай байдаг вэ? Ямар аргаар харилцахыг илүүд үздэг вэ?
8. Иргэд олон нийтийн Улсын Их Хурал болон төрийн бусад байгууллагад итгэх итгэлийг үнэлэх үнэлгээ ямар хэмжээнд байна вэ?
9. Орон нутгийн төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэд хэр сэтгэл ханамжтай байдаг вэ? Бэлчээрийн асуудлаар иргэд тухайн орон нутгийн хуралтай хэрхэн хамтран ажилладаг вэ? Хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?

Судалгааны арга зүй, аргачлал

Судалгааг олон нийтийн санаа бодлыг судлах КАР /knowledge, attitudes, and practices/ загвар буюу олон нийтийн мэдлэг, хандлага, оролцоог тодорхойлох загварыг ашиглан хэрэгжүүллээ. Энэхүү суурь судалгааны ажлыг дараах үе шатны дагуу гүйцэтгэсэн. Үүнд:

1. Судалгааны бэлтгэл үе шат, 2. Мэдээлэл цуглуулах үе шат, 3. Тайлагнах үе шат.

Бүдүүвч. Судалгааны ажлын арга зүйн зураглал

Судалгааны бэлтгэл үе шат



- Судалгааны удирдамж боловсруулах
- Судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах
- Тайлангийн бүтэц гаргах
- Хэрэглэгдэхүүнийг туршиш

Мэдээлэл цуглуулалтын үе шат



- IDI ганцаарчилсан ярилцлага
- CATI буюу утсаар авах асуулгын судалгаа
- Дата мэдээллийг хянах, шалгах
- SPSS программд өгөгдлийг оруулах

Тайлагнах үе шат



- Тоон судалгаанд дүн шинжилгээ хийх /SPSS программ/
- Чанарын судалгааг хэв загвар, бүлэглэл хийх, шигтгээ, кейс сонгох
- Судалгааны хураангуй болон дэлгэрэнгүй тайлан бэлтгэх
- Эцсийн тайлан

Судалгааны мэдээлэл цуглуулах арга

- Асуулгын арга (анкет)

Судалгааны анкетад судлах зүйлд дэвшүүлсэн асуултад хариулт өгөх, харьцуулан судлах, боловсруулах боломжтой хэлбэрээр бэлтгэсэн. Анкетын мэдээллийг

цуглуулахдаа САТИ (Computer-assisted telephone interviewing) аргачлалыг ашиглаж оролцогчдоос мэдээлэл авлаа.

Бид КОВИД-19 цар тахал гарсан буюу 2020 оны эхнээс техникийн боломж, ашиглалтын нөхцөл байдлыг судлан үзсэний үндсэн дээр мэдээлэл цуглуулалтын ажилдаа телефон утсаар мэдээллийг цуглуулах компьютерт суурилсан аргыг ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн.

Утсаар мэдээлэл цуглуулах давуу талууд:

- Цаг хугацаа, орон зайн хязгаарлалтаас үл хамааран мэдээллийг цуглуулах боломжтой.
- Үүрэн телефон холбооны сүлжээ нэвтэрсэн Монгол Улсын нийслэл, 9 дүүрэг, 152 хороо болон 21 аймаг 330 сумын төв бусад суурийн газруудад нэг зэрэг хүрч, богино хугацаанд мэдээллийг цуглуулах боломж.
- Судалгаанд оролцогчийг сонгох, тэдэнтэй холбогдох, ярилцлага хийх, мэдээллийг шивж оруулах, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг бүхий л үйл ажиллагаа автоматчилагдсан.
- Үзүүлэлтийн хязгаарыг зааж өгсөн логик шалгалт бүхий мэдээлэл оруулах программын дагуу алдаагүй мэдээлэл цуглуулах боломжийг бүрдүүлсэн.

• **Ярилцлагын арга (ганцаарчилсан болон бүлгийн)**

Ярилцлагаар анкетын асуулгад анзаарагдаагүй орхигдож болох нарийн асуудлууд, түүний шалтгаан нөхцөлийг тогтоох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар асуултуудыг оруулсан болно.

Судалгааны түүвэр

Үндэсний Статистикийн Хорооны 2020 оны хүн амын ээлжит тооллогын дүнгээр Монгол Улсын хэмжээнд 18-аас дээш насны нийт 2157011 хүн байна.¹ Энэ тоог түүврийн эх олонлог гэж үзэв.

Судалгааны үр дүнд итгэх интервал 95 хувь, алдааны түвшин 2.2 хувь байхаар тооцож, түүврийн тохиромжтой хэмжээг 1982-оос багагүй байхаар тооцоолов.² Тэгшитгэвэл 2000 юм.

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын түүврийн хувьд талбар бүрээс 3-7 хүнийг хамруулахаар тооцов.

Хүснэгт 1. Түүврийн бүтэц.

| № | Бүс | 18-аас дээш насны хүн ам | Нийт хүн амд эзлэх хувь | Түүврийн нарийвчлал |
|---|-------------|--------------------------|-------------------------|---------------------|
| 1 | Баруун бүс | 261034 | 12% | 240 |
| 2 | Хангайн бүс | 392165 | 18% | 360 |
| 3 | Төвийн бүс | 347957 | 16% | 320 |
| 4 | Зүүн бүс | 153261 | 7% | 140 |
| 5 | Улаанбаатар | 1002594 | 47% | 940 |
| | Нийт | 2157011 | 100% | 2000 |

¹ https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L03&type=tables YCX.

² <https://www.surveysystem.com/sscalc.htm> түүвэр тооцох систем

Талбарын судалгааг Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал³, Монгол Улсын захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд үндэслэн бүсчлэн хувааж, пропорционал хуваарилалтын аргыг ашиглан хуваарилав.

- Өмнө дурдсанчлан дараах нийгмийн бүлгийг заавал багтаана.
 - Алслагдсан бүс нутгийн оршин суугчид;
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд;
 - 15-17 насны хүүхэд, залуучууд;
 - Өрх толгойлсон эцэг эхчүүд.

Хүснэгт 2. Судалгааны нарийвчилсан түүвэр

| № | Бүсчлэл | Төлөөлөх аймаг, дүүрэг | Ярилцлагын тоо | Анкетын тоо |
|---|--|------------------------|----------------|-------------|
| 1 | Баруун бүс (Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай) | Баян-Өлгий | 3 | 90 |
| | | Ховд | 3 | 90 |
| | | Говь-Алтай | 3 | 60 |
| 2 | Хангайн бүс (Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Орхон) | Хөвсгөл | 3 | 120 |
| | | Өвөрхангай | 3 | 120 |
| | | Булган | 3 | 120 |
| 3 | Төвийн бүс (Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь) | Төв | 3 | 130 |
| | | Дорноговь | 3 | 110 |
| | | Говьсүмбэр | 3 | 80 |
| 4 | Зүүн бүс (Дорнод, Сүхбаатар, Хэнтий) | Дорнод | 3 | 50 |
| | | Сүхбаатар | 3 | 40 |
| | | Хэнтий | 3 | 50 |
| 5 | Нийслэл | Хан-Уул дүүрэг | 3 | 140 |
| | | Баянзүрх дүүрэг | 3 | 250 |
| | | Сонгинохайрхан дүүрэг | 3 | 250 |
| | | Чингэлтэй | 3 | 150 |
| | | Баянгол | 3 | 150 |

³ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 2001 он


БҮЛЭГ 1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ

Энэ бүлэгт судалгаанд оролцогчдын УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдлэг ойлголтод хамаарах судалгааны үр дүнг орууллаа.

УИХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх зорилготой www.parliament.mn веб сайтаас иргэд УИХ-ын тухай, УИХ-ын гишүүд, тэдний үйл ажиллагаа, УИХ-ын тамгын газрын тухай мэдээллүүд болон чуулганаар хэлэлцэж буй хуулийн төслүүд, асуудлуудын талаар мэдээлэл авах боломжтой юм.

Тэгвэл иргэд www.parliament.mn сайтын талаар мэдлэг мэдээлэл хангалтгүй хэмжээнд байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна..

График 1. Иргэд www.parliament.mn сайтын талаар мэддэг эсэх



Судалгаанд оролцогчдын 91.9 хувь нь УИХ-ын албан ёсны веб сайт болох www.parliament.mn ийн талаар мэдэхгүй, 8.1 хувь нь мэднэ гэж хариулсан. Мэднэ гэж хариулсан иргэдээс 1.3 хувь нь албан ёсны www.parliament.mn сайтыг андуурч өөр сайтаар нэрлэсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 6.8 хувь нь зөв хариулсан. Судалгаанд оролцогчид УИХ-ын албан ёсны веб сайтыг дараах веб сайтуудтай андуурч, албан ёсны сайт гэж нэрлэсэн тохиолдлууд гарсан. Үүнд:

- Khural.mn
- Government.mn
- Mongolia.gov.mn
- VIP76.mn
- Gogo.mn
- Ikon.mn
- Zasag.mn

УИХ-ын албан ёсны веб сайтын талаар мэддэг эсэх нь судалгаанд оролцогчдын боловсролоос хамаарч өссөн үзүүлэлт ажиглагдаж байна. Хамгийн өндөр боловсролтой буюу доктор зэрэгтэй хүмүүсийн 28.6 хувь нь УИХ-ын албан ёсны веб сайтын талаар мэдэж байгаа нь манай судалгаанд оролцсон иргэдээс www.parliament.mn веб сайтын талаар хамгийн сайн мэдлэг мэдээлэлтэй бүлэг болж байгаа юм.

Хүснэгт 3. УИХ-ын албан ёсны веб сайтын талаар мэддэг эсэх, боловсролоор

| № | Боловсролын түвшин | УИХ-ын албан ёсны веб сайтын талаар мэднэ | УИХ-ын албан ёсны веб сайтын талаар мэдэхгүй |
|---|--------------------|---|--|
| 1 | Боловсролгүй | 0.0% | 100.0% |
| 2 | Бага | 0.0% | 100.0% |
| 3 | Бүрэн бус дунд | 2.8% | 97.2% |
| 4 | Бүрэн дунд | 3.2% | 96.8% |
| 5 | Тусгай дунд | 1.3% | 98.7% |
| 6 | Бакалавр | 10.7% | 89.3% |
| 7 | Магистр | 19.8% | 80.2% |
| 8 | Доктор | 28.6% | 71.4% |

Судалгаанд оролцогчид УИХ-аар хэлэлцэгдэж буй хуулийн төслүүдтэй танилцах болон санал өгөх дөө Lawforum.parliament.mn веб сайтыг хэрхэн ашиглаж байгааг бүсчлэлээр харууллаа.


Хүснэгт 4 Хуулийн төсөлд иргэдийн саналыг тусгах Lawforum.parliament.mn талбарыг ашиглаж байсан эсэх, байршилаар

| № | Байршил | Үргэлж | Ихэвчлэн | Заримдаа | Хааяа | Огт үгүй | Мэдэхгүй | Нийт |
|---|-----------------|--------|----------|----------|-------|----------|----------|--------|
| 1 | Баруун бүс | 2.5% | 3.7% | 10.7% | 12.0% | 64.0% | 7.0% | 100.0% |
| 2 | Хангайн бүс | 0.7% | 1.4% | 7.4% | 9.9% | 72.2% | 8.5% | 100.0% |
| 3 | Төвийн бүс | 2.1% | 1.8% | 10.3% | 8.5% | 62.6% | 14.7% | 100.0% |
| 4 | Зүүн бүс | 1.1% | 3.8% | 13.2% | 9.3% | 61.0% | 11.5% | 100.0% |
| 5 | Улаанбаатар хот | 1.2% | 2.4% | 7.2% | 11.4% | 69.0% | 8.7% | 100.0% |
| 6 | Нийт | 1.4% | 2.5% | 8.8% | 10.6% | 67.1% | 9.8% | 100.0% |

Монгол улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтарсан “Монгол улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор Lawforum.parliament.mn цахим системийг бүтээсэн. Уг систем нь 2021 оны 3 дугаар сард олон нийтэд нээлттэй болсон, судалгаанд оролцогчид Lawforum.parliament.mn сайтын талаар хангалттай мэдлэг мэдээлэлтэй болоогүй байна. Нийт судалгаанд оролцогчдын 1.4 хувь нь Lawforum.parliament.mn сайтын тогтмол хэрэглэгчид бол 76.9 хувь нь огт хэрэглэж байгаагүй болон мэдэхгүй гэж хариулсан.

Иргэдийн 42.9 хувь нь УИХ-ын үйл ажиллагааны талаар сонирхдог бол 36.6 хувь нь заримдаа сонирхдог гэж хариулжээ.

График 2 Судалгаанд оролцогчдын УИХ-ын үйл ажиллагааны талаар сонирхдог байдал



УИХ-ын үйл ажиллагааны талаар гурван хүн тутмын нэг нь сонирхдог бол таван хүн тутмын нэг нь сонирхдоггүй болон мэдэхгүй гэж хариулсан байна. Иргэдийн дийлэнх буюу 42.9 хувь нь УИХ-ын үйл ажиллагааны талаар заримдаа сонирхдог байна.

Хүснэгт 5 УИХ-ын үйл ажиллагааны талаар сонирхдог байдал, хөдөлмөр эрхлэлтээр

| № | Хөдөлмөр эрхлэлт | Сонирхдог | Заримдаа сонирхдог | Сонирхдоггүй | Мэдэхгүй | Нийт |
|----|-------------------------|-----------|--------------------|--------------|----------|--------|
| 1 | Төрийн байгууллага | 46.1% | 40.2% | 12.2% | 1.5% | 100.0% |
| 2 | Олон улсын байгууллага | 28.4% | 45.1% | 25.3% | 1.2% | 100.0% |
| 3 | Төрийн бус байгууллага | 38.5% | 46.2% | 15.4% | 0.0% | 100.0% |
| 4 | Хувийн байгууллага | 37.5% | 43.8% | 18.8% | 0.0% | 100.0% |
| 5 | Хувиараа бизнес эрхлэгч | 26.8% | 46.3% | 25.0% | 1.8% | 100.0% |
| 6 | Оюутан | 36.1% | 37.5% | 26.0% | 0.3% | 100.0% |
| 7 | ЕБС-ийн сурагч | 10.3% | 55.6% | 34.2% | 0.0% | 100.0% |
| 8 | Тэтгэвэрт | 0.0% | 20.0% | 60.0% | 20.0% | 100.0% |
| 9 | Группт | 47.6% | 42.5% | 9.5% | 0.4% | 100.0% |
| 10 | Малчин | 46.1% | 40.2% | 12.2% | 1.5% | 100.0% |
| 11 | Ажил эрхлэхгүй байгаа | 25.2% | 45.3% | 28.8% | 0.7% | 100.0% |
| 12 | Нийт | 17.4% | 56.5% | 17.4% | 8.7% | 100.0% |

Төрийн албан хаагчид, малчид, группэд байдаг иргэдийн хувьд УИХ-ын үйл ажиллагааны талаар илүү их сонирхож байна. Тухайлбал төрийн албан хаагчдын хувьд ажлынхаа шаардлагаар УИХ-ын мэдээ мэдээлэлтэй илүү ойр байдаг бол малчид, групп тогтоолгосон иргэдийн хувьд мэдээлэл авах эх үүсвэр нь илүү уламжлалт хэлбэртэй байна. Өдөр тутмын телевизийн мэдээ үздэг, мэдээгээр харсан гэх зэрэг хариултаар түгээмэл байна.

Шигтгээ:

УИХ-ын үйл ажиллагаа болон гишүүдийн талаар үнэн худал нь мэдэгдэхгүй олон мэдээлэл гардаг болохоор сүүлдээ юунд итгэх юунд итгэхгүйгээ ч мэдэхгүй байна. Телевизийн сувгуудаар гарч байгаа мэдээнүүдэд итгэх хэцүү байгаа шалтгаан нь ард нь дандаа улс төрчид байдаг болохоор итгэдэггүй. Тэр бүр мэдээлүүдийн үнэн зөвийг ялгаад нягтлаад суух боломж хомс байна.

Дорноговь аймгийн харьяат, 46 настай, Малчин

“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтийн ойлголт, санаа бодол” судалгааны тайлан

Хүснэгт 6 УИХ-ын үйл ажиллагааны талаар сонирхдог байдал, гэр бүлийн байдлаар

| № | Гэр бүлийн байдал | Сонирхдог | Заримдаа сонирхдог | Сонирхдоггүй | Мэдэхгүй | Нийт |
|---|-------------------|-----------|--------------------|--------------|----------|--------|
| 1 | Гэрлэсэн | 41.0% | 41.0% | 16.9% | 1.1% | 100.0% |
| 2 | Гэрлээгүй | 18.1% | 50.7% | 29.6% | 1.6% | 100.0% |
| 3 | Өрх толгойлсон | 40.2% | 36.4% | 22.4% | 0.9% | 100.0% |
| 4 | Бэлэвсэн | 34.1% | 53.7% | 12.2% | 0.0% | 100.0% |
| 5 | Нийт | 36.6% | 42.9% | 19.5% | 1.2% | 100.0% |

Гэрлэсэн болон бэлэвсэн, өрх толгойлсон иргэд УИХ-ын үйл ажиллагааны талаар илүү их сонирхдог. Харин гэрлээгүй иргэдийн хувьд дөнгөж 18.1 хувь нь л УИХ-ын үйл ажиллагааны талаар сонирхдог байна.

Шигтгээ

Төрөөс тэтгэмж авдаг болохоор, засгийн газрын болон УИХ-ын шийдвэрүүдийг аль болох анхаарч сонсохыг хичээдэг. Өрх толгойлсон олон хүүхэдтэй эхчүүдийг илүү сайн дэмжээсэй гэж боддог

Төв аймгийн харьяат, Өрх толгойлсон ээж

Хүснэгт 7 Хуулийн төсөлд санал өгөх, хууль боловсруулах үйл ажиллагаанд оролцох боломж. Дундаж утгууд. (1-огт хангалтгүй, 10-бүрэн хангалттай)


| Гэрлэлтийн байдал | | |
|-------------------|-----------------|------|
| | Гэрлэсэн | 4.08 |
| | Гэрлээгүй | 4.35 |
| | Өрх толгойлсон | 3.89 |
| | Бэлэвсэн | 4.07 |
| Байриллаар | | |
| | Баруун бүс | 4.39 |
| | Хангайн бүс | 4.35 |
| | Төвийн бүс | 4.27 |
| | Зүүн бүс | 4.23 |
| | Улаанбаатар хот | 3.92 |
| Хүйс | | |
| | Эрэгтэй | 4.09 |
| | Эмэгтэй | 4.15 |
| Нийт | | 4.12 |

Судалгаанд оролцогчдын хуулийн төсөлд санал өгөх болон хууль боловсруулах үйл ажиллагаанд оролцох боломжтой байдлыг 10 онооноос дунджаар 4.12 оноогоор үнэлсэн. Хууль боловсруулах, хуулийн төсөлд санал өгөхдөө УИХ-ын Тамгын газраас бүтээсэн иргэдийг хуулийн төслүүдтэй танилцах болон санал авах зорилготой Lawforum.parliament.mn веб сайтыг судалгаанд оролцсон иргэдийн 76.9 хувь нь огт мэдэхгүй болон ашиглаж байгаагүй байна. Хувиар илэрхийлбэл иргэд УИХ-ын үйл ажиллагаанд оролцох боломжоо 41.2 хувь гэж үнэлжээ.

УИХ-ын бүтэц, үйл ажиллагааны талаар иргэдийн мэдлэг ойлголтыг дараах графикт үзүүлээ. Үүнд УИХ-ын бүтэц зохион байгуулалт, намын бүлгийн үйл ажиллагаа,


байнгын болон түр хороо, хууль хэлэлцэх батлах үйл явц, УИХ-аас хуулийн хэрэгжилт, гүйцэтгэх засаглалд тавих хяналтыг хамруулсан.

График 3 УИХ-ын бүтэц, үйл ажиллагаануудын талаарх иргэдийн мэдлэг ойлголт



УИХ-ын чиг үүргүүдийн талаар иргэд хэр зэрэг мэдлэг мэдээлэлтэй байгааг доор харууллаа. Уг асуулт нь олон сонголттой бөгөөд давхардсан тоогоор нийт 5389 сонголтоос эзлэх хувийг харууллаа.

График 4. Судалгаанд оролцогчдын УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаар мэдлэг ойлголт



УИХ-ын үндсэн чиг үүргүүдийг үнэлүүлэхдээ “төсөв санаачлах” буюу чиг үүрэгт хамааралгүй хариултыг шалгах зорилгоор оруулсан бөгөөд энэ нь хамгийн бага 21.35 хувь буюу бусад хариултаас 2 дахин цөөн байгаа нь иргэдийн ойлголт мэдлэгийг тандах, судалгааны чанарыг хэмжих боломж олгож байна. Нийт судалгаанд оролцогчдын 57.35 хувь нь хууль санаачлах, 57.6 хувь нь хууль батлах үйл ажиллагааг УИХ-ын үндсэн чиг үүрэгт хамаарна гэж хариулсан. 46.75 хувь нь Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, 43.1 хувь нь ЗГ-ын үйл ажиллагаанд хяналт тавих, 43 хувь нь төсөв батлах ажил нь УИХ-ын үндсэн чиг үүрэгт хамаарна гэж үзсэн байна. Харин судалгаанд оролцогчдын хамгийн бага хувь нь буюу 21.35 хувь нь төсөв санаачлах үйл ажиллагааг УИХ-ын үндсэн чиг үүрэгт холбогдох ажил гэж үзсэн байна.

Хүснэгт 8. УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаар мэдлэг ойлголт, хүйсээр

| № | УИХ-ын чиг үүргүүд | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---|---------|--------|---------|--------|
| | | Тоогоор | Хувиар | Тоогоор | Хувиар |
| 1 | Хууль санаачлах | 560 | 60.0% | 587 | 55.1% |
| 2 | Хууль батлах | 569 | 61.0% | 583 | 54.7% |
| 3 | Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих | 461 | 49.4% | 474 | 44.5% |
| 4 | Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих | 412 | 44.2% | 450 | 42.3% |
| 6 | Төсөв батлах | 415 | 44.5% | 445 | 41.8% |

УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаарх иргэдийн ойлголт нь судалгаанд оролцогчдын хүйсээс хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал эрэгтэйчүүдийн хувьд УИХ-ын чиг үүргүүдийн талаарх мэдлэг ойлголт нь эмэгтэйчүүдээс 1-2 хувиар өндөр байна.

Хүснэгт 9. УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаар мэдлэг ойлголт, боловсролоор

| № | | Боловсролгүй n=9 | Бага боловсрол n=35 | Бүрэн бус дунд n=145 | Бүрэн дунд n=537 | Тусгай дунд n=155 | Бакалавр n=919 | Магистр n=193 | Доктор n=7 |
|---|---|---------------------|------------------------|-------------------------|---------------------|----------------------|-------------------|------------------|---------------|
| 1 | Хууль санаачлах | 77.8% | 42.9% | 46.2% | 49.7% | 61.9% | 62.2% | 62.2% | 71.4% |
| 2 | Хууль батлах | 55.6% | 48.6% | 50.3% | 44.7% | 56.8% | 65.2% | 66.8% | 28.6% |
| 3 | Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих | 22.2% | 25.7% | 37.2% | 41.3% | 45.8% | 51.8% | 50.8% | 57.1% |
| 4 | Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих | 0.0% | 25.7% | 31.7% | 37.1% | 36.1% | 49.7% | 48.7% | 28.6% |
| 5 | Төсөв батлах | 11.1% | 17.1% | 32.4% | 34.5% | 42.6% | 49.2% | 51.3% | 57.1% |

Судалгаанд оролцогчдын УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаарх ойлголт нь боловсролын төвшнөөрөө ялгаатай байна. Тухайлбал, боловсролгүй иргэдийн хамгийн их буюу 77.8 хувь нь хууль санаачлах эрхийн талаар сайн мэдэж байгаа бол Бага боловсролтой иргэд болон бүрэн дунд боловсролтой иргэдийн хувьд хууль батлах чиг үүргийн талаар мэдлэг ойлголт хамгийн өндөр буюу 48.6 хувь, 50.33 хувь хувь тус тус байна. Бүрэн дунд болон тусгай дунд боловсролтой иргэдийн хувьд хамгийн сайн мэддэг чиг үүрэг нь хууль санаачлах чиг үүрэг бөгөөд эдгээр нь 49.7 хувь , 61.9 хувь байна. Бакалавр болон магистр зэрэгтэй хүмүүсийн хувьд хууль батлах чиг үүргийн талаар хамгийн сайн мэддэг (65.2 хувь, 66.8 хувь) байна. Доктор зэрэгтэй хүмүүсийн хувьд хууль санаачлах (71.4 хувь) чиг үүргийн талаар хамгийн сайн мэдлэг ойлголттой байна.

Иргэдийн боловсролын түвшин ахих тусам УИХ-ын чиг үүргүүдийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдэж байна.

Хүснэгт 10. УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаар мэдлэг ойлголт, байрилаар

| № | УИХ-ын чиг үүргүүд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар хот |
|---|---|------------|-------------|------------|----------|-----------------|
| 1 | Хууль санаачлах | 52.5% | 56.7% | 54.1% | 60.4% | 59.6% |
| 2 | Хууль батлах | 56.6% | 56.3% | 61.8% | 70.3% | 54.4% |
| 3 | Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих | 42.6% | 41.9% | 52.1% | 56.0% | 45.7% |
| 4 | Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих | 50.0% | 39.4% | 43.5% | 56.0% | 39.9% |
| 5 | Төсөв батлах | 43.8% | 47.9% | 44.4% | 58.2% | 37.9% |

Газар нутгийн байршил, бүсчлэлээс хамааран иргэдийн УИХ-ын талаарх мэдлэг ойлголтод илт ялгаа, зөрөө байхгүй байна.

Шигтгээ:

Хөдөөгүүр интернэттэй газар байгаа айлууд нь Facebook-ээс их мэдээлэл авдаг. Ер нь бол хотод болж байгаа мэдээллүүдийг цал алдалгүй авч чаддаг. Харин бид өөрсдийнхөө дуу хоолойг гишүүдэд хангалттай хүргэж чаддаггүй. Нөгөө талаасаа хүмүүс үнэн худал нь сайн мэдэгдэхгүй маш олон сувгуудаас ихэвчлэн сөрөг мэдээллүүд авдаг болохоор иргэдийн улс төрчдийн талаар ойлголт улам бүр муудаж байна.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Төрийн албан хаагч, 36 настай

Хүснэгт 11. УИХ-ын үндсэн чиг үүргүүдийн талаар мэдлэг ойлголт, гэр бүлийн байдлаар

| № | УИХ-ын чиг үүргүүд | Гэрлэсэн | Гэрлээгүй | Өрх толгойлсон | Бэлэвсэн |
|---|---|----------|-----------|----------------|----------|
| 1 | Хууль санаачлах | 57.0% | 55.5% | 60.7% | 82.9% |
| 2 | Хууль батлах | 59.0% | 53.1% | 51.4% | 65.9% |
| 3 | Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих | 47.7% | 43.5% | 44.9% | 51.2% |
| 4 | Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих | 44.3% | 37.9% | 44.9% | 43.9% |
| 5 | Төсөв батлах | 43.4% | 40.8% | 43.0% | 48.8% |


Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдлаас үл хамааран иргэдийн дийлэнх нь хууль санаачлах болон хууль батлах чиг үргийн талаар ойлголт нь хамгийн өндөр байна.

БҮЛЭГ 2. УИХ-ЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН САНАА БОДОЛ, ҮНЭЛГЭЭ

Уг бүлэгт судалгаанд оролцсон иргэдийн УИХ-ын үйл ажиллагааны талаарх үнэлгээг оролцогчдын байршил, хүйс, нас, боловсрол, орлого зэрэгтэй харьцуулан авч үзлээ. Үнэлгээг УИХ-ын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ болон чиг үүрэгтэй холбогдох асуултууд дэвшүүлж 1-5 болон 1-10 оноогоор үнэлүүлж гаргасан.


УИХ-ын үйл ажиллагааг судалгаанд оролцогчид хэрхэн үнэлсний доор графикт харууллаа.

График 5 УИХ-ын үйл ажиллагааны өөрчлөлтийг үнэлэх үнэлгээ



Судалгаанд оролцсон иргэдийн 43.9 нь УИХ-ын үйл ажиллагааг хэвэндээ, 20.4 хувь нь сайжирсан, 31.3 хувь нь муудаж байна гэж дүгнэжээ. Дараах графикт уг үнэлгээг насны бүлэг тус бүрээр харьцуулан үзүүллээ.

График 6 УИХ-ийн үйл ажиллагаа сайжирч байгаа эсэх, насны бүлгээр



Насны бүлгээр харьцуулан үзвэл УИХ-ын үйл ажиллагааг 56-аас дээш насныхан илүү өөдрөгөөр, 18-35 залуучууд бусад бүлэгтэй харьцуулбал сөргөөр дүгнэж байна. Нийтлэг

“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтийн ойлголт, санаа бодол” судалгааны тайлан

байдлаар насны бүлгүүдээс үл харгалзан УИХ-ын үйл ажиллагааг ерөнхийд нь хэвэндээ байна гэх дүгнэлт давамгайл байна.

Хүснэгт 12 УИХ-ын үйл ажиллагааны талаарх үнэлгээ, орлогоор


| № | Сарын орлого | Сайжирч байна | Хэвэндээ байна | Муудаж байна | Мэдэхгүй |
|---|--------------------------|---------------|----------------|--------------|----------|
| 1 | 300 мянган төгрөг хүртэл | 18.8% | 44.2% | 32.3% | 4.6% |
| 2 | 300-500 мянган төгрөг | 15.8% | 50.5% | 27.1% | 6.7% |
| 3 | 500 мянгаас 1 сая төгрөг | 22.1% | 43.3% | 29.9% | 4.7% |
| 4 | 1-2 сая төгрөг | 29.4% | 39.1% | 28.2% | 3.2% |
| 5 | 2-оос дээш сая төгрөг | 16.7% | 38.9% | 42.2% | 2.2% |
| 6 | Нийт | 20.4% | 43.9% | 31.2% | 4.6% |

Хүснэгт 13 УИХ-ын үйл ажиллагаанд өгөх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, байршлаар

| № | Байршил | Оноо /1-10/ |
|---|-------------|-------------|
| 1 | Дундаж | 4.56 |
| 2 | Улаанбаатар | 4.29 |
| 3 | Баруун бүс | 4.93 |
| | Хангайн бүс | 4.78 |
| | Төвийн бүс | 4.66 |
| | Зүүн бүс | 4.93 |
| | Орон нутаг | 4.80 |

Судалгаанд оролцогчдын УИХ-ын үйл ажиллагааг үнэлэх үнэлгээ 10 онооноос Улаанбаатарт 4.29 оноо, орон нутагт 4.8 оноо байгаа нь нийслэлийн иргэдээс илүү хөдөө орон нутаг УИХ-ын нэр хүнд үнэлэмж өндөр байгааг харуулж байна. Нарийвчлан авч үзвэл төвөөс алслагдах тусам үнэлгээ өсөж, төв рүү ойртох тусам үнэлгээ буурч байна. Нийслэлээс алслагдсан баруун бүс 4.93 болон зүүн бүс 4.93 оноотой байгаа бол нийслэлд ойр хангайн бүс 4.78, төвийн бүс 4.66 оноо өгсөн нь орон нутгийн дундаж үнэлгээнээс доогуур үзүүлэлт болж байна.

График 7. УИХ-ын үйл ажиллагаанд өгөх иргэдийн дундаж үнэлгээ, хүйсээр /1-10 оноо/



УИХ-ын үйл ажиллагаа болон гишүүдийн хариуцлагыг үнэлэх иргэдийн үнэлгээнд хүйсийн ялгаа төдийлөн гарахгүй байна. Эрэгтэйчүүд парламентын үйл ажиллагаа болон гишүүдийн хариуцлагыг эмэгтэйчүүдээс үл ялиг /0.11 оноо/ дээгүүр үнэлж байна.

Хүснэгт 14 Иргэдийн үнэлгээ, насны бүлгээр

| № | Нас | УИХ-ын үйл ажиллагааг үнэлэх сэтгэл ханамж /1-10 хүртэлх оноо/ | Хуулийн төсөлд иргэд саналаа өгөх, хууль боловсруулах үйл ажиллагаанд оролцох боломж /1-10 хүртэлх оноо/ | УИХ-ын гишүүдийн хариуцлагад өгөх үнэлгээ. /1-10 хүртэлх оноо/ |
|---|------------------|--|--|--|
| 1 | 18-35 нас | 4.36 | 4.27 | 4.05 |
| 2 | 36-55 нас | 4.58 | 4.01 | 4.34 |
| 3 | 56- аас дээш нас | 5.01 | 4.03 | 4.31 |
| 4 | Дундаж | 4.56 | 4.12 | 4.21 |


УИХ-ын үйл ажиллагаанд хамгийн өндөр үнэлгээг 56-аас дээш насны иргэд өгсөн. УИХ-ын гишүүдийн хариуцлагыг 36-55 насныхан хамгийн өндрөөр үнэлсэн бол хуулийн төсөлд санал өгөх, оролцох боломжийг 13-35 хүртэлх насны залуучууд хамгийн өндрөөр үнэлжээ. Үнэлгээ тус бүрийн хамгийн өндөр оноог өөр өөр насны бүлгүүд өгсөн нь анхаарал татаж байгаа юм. Жишээлбэл хуулийн төсөлд иргэд саналаа өгөх, үзэл бодлоо илэрхийлж оролцох боломж цахим технологид суурилж хөгжиж байгаа буюу залуучуудын хэрэглээнд илүү ойртож байна.

Ярилцлагын хэсгээс:

Яг хууль боловсруулахад саналаа өгдөг сайтын тухайд бол мэдэхгүй юм байна. Гэхдээ тойргоосоо сонгогдсон гишүүдийн нэйжийг дагадаг. Тэндээсээ зарим хэрэгтэй мэдээллүүдийг хардаг. Ер нь яг ямар хуулийн төсөл ямар дарааллаар явдгийг нь мэдэхгүй, ойлгомжгүй санагддаг. Шүүмжлэх ч юм уу саналаа хэлэх шаардлага гарвал фэйсбүүкээр илэрхийлчихдэг.

Сонгинохайрхан дүүргийн харьяат. 23 настай, эрэгтэй.

График 8. УИХ-ын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ, байрилаар /1-5 оноо/



“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтийн ойлголт, санаа бодол” судалгааны тайлан

УИХ-ын үйл ажиллагааг сэдэвчилж үр дүнг үнэлүүлэхэд дараах дүр зураг гарч байна. УИХ-ын үйл ажиллагаанаас хамгийн өндөр үнэлгээг 3.11 оноогоор УИХ-аас засгийн газарт тавих хяналт, Хууль санаачлах эрхээ хэрэгжүүлдэг байдал 2.66 оноо тус тус байна. УИХ-ын дахь сөрөг хүчний үйл ажиллагааг хангалтгүй буюу 2.45 оноогоор үнэлжээ. Байршлаар харьцуулж харвал хөдөө орон нутгийн иргэд Улаанбаатар хотынхоос илүү өндөр үнэлгээг өгч байна.

Ярилцлагын хэсгээс

Парламент иргэдийн төлөөлөл гэдэг утгаараа нийгмийн янз бүрийн төлөөллийг багтаах нь зөв ч хууль тогтоох төрийн эрх барих дээд институтийн хувьд ямар ч хүн орж ирсэн үйл ажиллагаа нь хэвийн үргэлжлэх чадамжтай байх ёстой. Одоогийн УИХ-ын үйл ажиллагааг дүгнэхэд ковидын үеийн нөхцөл байдалд суурилсан нөгөө талаас далимдуулсан гэж хэлж болох хүний эрхийн маш олон ноцтой зөрчлүүдийг зохицуулж чадахгүй байна. Засгийн газарт хариуцлага тооцож, хянаж иргэдийнхээ төлөөлөл болж ажиллах чадамжгүй их хурал болоод байна. Хүний эрхийг хамгаалах хангахад их хурлын үүрэг оролцоо хамгийн чухал ч, энэ чиглэлд бодитой ажил хийж чадсангүй.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг оршин суугч, Их сургуулийн багш , 39 настай эмэгтэй

Парламент дахь сөрөг хүчин сул байх нь парламентын дотоод хяналтыг бууруулах эрсдэлтэй. Судалгаанд оролцогчид парламент дахь сөрөг хүчний төлөөллийн үйл ажиллагааг 5-аас 2.45 оноогоор дүгнэсэн.

Ярилцлагын хэсгээс:

Хөвсгөл аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч М. 34 настай


Манай аймагт ардчилсан нам олонх болсон. Гэвч нийт намаараа задралтай, нэгдсэн удирдлага олж чадахгүй тун хүнд байна. Дээгүүрээ бол талцаад байдаг, гэвч орон нутагт байдаг жирийн гишүүдийн хувьд туйлын хүнд байдаг. Улс төрийн сонголтоосоо болж ажил төрөл, амьдралаараа хохирч байна. Намаа нэгтгэж жирийн олон гишүүд дэмжигчдийнхээ итгэлийг сэргээх, үйл ажиллагаагаа шинэчлэх зайлшгүй хэрэгтэй. Намын асуудлаасаа болоод их хуралд ч үр дүнтэй ажиллаж чадахгүй байна.

Хүснэгт 15. Иргэн бүр сонгосон гишүүнээрээ дамжуулан хууль боловсруулах үйл ажиллагаанд саналаа өгөх, оролцох боломжтой эсэх үнэлгээ, бүсээр

| № | Байршил | Бүрэн санал нийлнэ | Санал нийлнэ | Зарим талаар санал нийлнэ | Санал нийлэхгүй | Огт санал нийлэхгүй | Мэдэхгүй |
|---|-----------------|--------------------|--------------|---------------------------|-----------------|---------------------|----------|
| 1 | Баруун бүс | 3.7% | 18.6% | 29.8% | 26.4% | 10.7% | 10.7% |
| 2 | Хангайн бүс | 2.1% | 13.0% | 33.5% | 34.2% | 8.5% | 8.8% |
| 3 | Төвийн бүс | 3.8% | 12.9% | 29.1% | 36.5% | 7.9% | 9.7% |
| 4 | Зүүн бүс | 3.3% | 15.4% | 31.9% | 33.5% | 8.2% | 7.7% |
| 5 | Улаанбаатар хот | 1.6% | 11.2% | 29.2% | 39.0% | 9.9% | 9.1% |
| 6 | Нийт | 2.5% | 13.1% | 30.1% | 35.9% | 9.3% | 9.3% |

Сонгосон гишүүнээрээ дамжуулан хууль боловсруулах үйл ажиллагаанд саналаа өгөх, оролцох боломжид нийт судалгаанд оролцогчид хангалтгүй гэж үнэлсэн нь давамгайл байна. Энэ нь хууль боловсруулах үйл ажиллагаанд саналаа өгөхөд өөрийн тойргийг төлөөлж буй гишүүнээр дамжуулж оролцох нь боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна. Гишүүдээр дамжуулахгүй цахим системээр хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцох боломж, мэдлэгийн тухайд уг судалгааны дараагийн бүлэгт дэлгэрүүлэн авч үзэх болно.

График 9. УИХ-ын үйл ажиллагааны хүртээмжтэй байдлын үнэлгээ, байршилаар



УИХ-ын үйл ажиллагааны хүртээмж гэдэгт их хурлын үйл ажиллагааны ил тод байдал, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хэлэлцэх хариу өгөх үйл явц, олон нийтийг мэдээллээр хангах, хурлын үйл ажиллагаа иргэдэд ээлтэй хялбар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хялбар хүртээмжтэй байх зэрэг ойлголтуудыг авч үзэж үнэллээ. Нийт үнэлгээний дундаж 2.5-2.9 онооны хооронд хэлбэлзэж байна. Байршлаар харьцуулж үзэхэд хөдөө орон нутагт Улаанбаатар хотоос илүү өндөр үнэлгээг өгсөн.

Хүснэгт 16. УИХ-ын үйл ажиллагааны хүртээмжтэй байдлын үнэлгээ

| № | Өргөдөл гомдол шийдвэрлэх журмын хэрэгжилт, эргэж хариу өгдөг байдал | 2.7 |
|---|---|------|
| 1 | УИХ-ын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал | 2.9 |
| 2 | Мэдээллийн ил тод байдал ба иргэд, олон нийтийг мэдээллээр хангах байдал | 2.69 |
| 3 | Иргэд, олон нийтээс хуулийн төсөлд санал авах, хэлэлцүүлэх, оролцуулах байдал | 2.57 |
| 4 | УИХ-ын үйл ажиллагаа иргэдэд ээлтэй, хялбар, төвөгтэй бус хэрэгсэл ашигладаг байвал | 2.5 |
| 5 | УИХ-ын баримт бичгийн хүртээмжтэй байдал | 2.68 |

График 10. УИХ-ын үйл ажиллагааг үнэлэх сэтгэл ханамж, насны бүлгээр /1-10 оноогоор/





График 11. УИХ-ын гишүүдийн хариуцлагад өгөх үнэлгээ, насны бүлгээр /1-10 оноогоор/




УИХ залуучуудын дунд хамгийн бага үнэлгээтэй байна. Залуучууд УИХ-ын үйл ажиллагаанд 10 онооноос 4.36, гишүүдийн хариуцлагыг 4.05 буюу хамгийн багаар үнэлжээ.

Хүснэгт 17. УИХ-ын гишүүд хууль санаачлах эрхээ үр нөлөөтэй гүйцэтгэдэг байдалд өгсөн үнэлгээ

| № | Байршил | Бүрэн санал нийлнэ | Санал нийлнэ | Зарим талаар санал нийлнэ | Санал нийлэхгүй | Огт санал нийлэхгүй | Мэдэхгүй |
|---|-----------------|--------------------|--------------|---------------------------|-----------------|---------------------|----------|
| 1 | Баруун бүс | 2.9% | 15.3% | 45.0% | 21.9% | 9.1% | 5.8% |
| 2 | Хангайн бүс | 2.5% | 8.5% | 50.4% | 29.9% | 4.6% | 4.2% |
| 3 | Төвийн бүс | 2.4% | 11.5% | 41.2% | 29.1% | 7.6% | 8.2% |
| 4 | Зүүн бүс | 1.1% | 9.3% | 53.8% | 26.4% | 4.9% | 4.4% |
| 5 | Улаанбаатар хот | 0.7% | 7.7% | 43.3% | 35.2% | 7.1% | 6.0% |
| 6 | Нийт | 1.6% | 9.5% | 45.1% | 31.0% | 6.9% | 6.0% |

УИХ-ын гишүүд хууль санаачлах эрхээ үр нөлөөтэй гүйцэтгэдэг гэдэгтэй нийт судалгаанд оролцсон 3 хүн тутмын нэг нь үзэж байна. Бүсчлэлээр авч үзвэл орон зайн хувьд төвөөс буюу Улаанбаатар хотоос хамгийн алслагдсан бүс болох Баруун бүсийн оршин суугчдын хувьд УИХ хууль санаачлах эрхээ өр нөлөөтэй гүйцэтгэдэг гэж хамгийн өндөр хувь нь үзэж байна. Харин Улаанбаатар хотын иргэдийн хувьд УИХ хууль санаачлах эрхээ үр нөлөөтэй хэрэгжүүлж чаддаггүй гэж үзэх нь давамгайл байна.

График 12. УИХ-аас баталсан хууль, тогтоол хэр зэрэг биелэгддэг вэ?



УИХ-аас баталсан хууль, тогтоол үргэлж биелдэг гэж судалгаанд оролцогчдын зөвхөн 2.4 хувь нь хариулсан бол огт биелэгддэггүй гэж 8.6 хувь нь үзэж байна. Судалгаанд

“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтийн ойлголт, санаа бодол” судалгааны тайлан

оролцогчдын 7.2 хувь нь мэдэхгүй байгаа бол үлдсэн 81.8 хувь нь ихэвчлэн, заримдаа болон хааяа биелдэг гэж үзэж байна.

Хүснэгт 18 УИХ-аас баталсан хууль, тогтоол биелэгддэг гэж үздэг байдал, боловсролын төвшинөөр

| № | Боловсрол | Үргэлж | Ихэвчлэн | Заримдаа | Хааяа | Огт үгүй | Мэдэхгүй | Нийт |
|---|----------------|--------|----------|----------|-------|----------|----------|--------|
| 1 | Боловсролгүй | 11.1% | 11.1% | 33.3% | 22.2% | 11.1% | 11.1% | 100.0% |
| 2 | Бага | 5.7% | 5.7% | 31.4% | 31.4% | 2.9% | 22.9% | 100.0% |
| 3 | Бүрэн бус дунд | 2.8% | 8.3% | 49.0% | 20.7% | 6.2% | 13.1% | 100.0% |
| 4 | Бүрэн дунд | 1.7% | 8.2% | 41.0% | 33.5% | 8.9% | 6.7% | 100.0% |
| 5 | Тусгай дунд | 1.3% | 13.5% | 37.4% | 28.4% | 14.8% | 4.5% | 100.0% |
| 6 | Бакалавр | 2.6% | 17.4% | 39.5% | 26.3% | 7.3% | 6.9% | 100.0% |
| 7 | Магистр | 2.6% | 20.7% | 36.3% | 25.4% | 9.8% | 5.2% | 100.0% |
| 8 | Доктор | 0.0% | 14.3% | 0.0% | 28.6% | 42.9% | 14.3% | 100.0% |
| 9 | Нийт | 2.4% | 14.1% | 39.8% | 28.0% | 8.6% | 7.3% | 100.0% |

Хүснэгт 19 УИХ-аас баталсан хууль, тогтоолын биелэлтийг орлоготой харьцуулбал

| № | Орлого | Үргэлж | Ихэвчлэн | Заримдаа | Хааяа | Огт үгүй | Мэдэхгүй | Нийт |
|---|--------------------------|--------|----------|----------|-------|----------|----------|--------|
| 1 | 300 мянган төгрөг хүртэл | 2.7% | 10.8% | 40.8% | 31.2% | 7.3% | 7.3% | 100.0% |
| 2 | 300-500 мянган төгрөг | 2.1% | 10.3% | 42.4% | 27.3% | 10.3% | 7.6% | 100.0% |
| 3 | 500 мянгаас 1 сая төгрөг | 2.7% | 16.9% | 40.9% | 26.1% | 7.6% | 5.8% | 100.0% |
| 4 | 1-2 сая төгрөг | 4.0% | 23.8% | 37.9% | 24.6% | 5.6% | 4.0% | 100.0% |
| 5 | 2-оос дээш сая төгрөг | 0.0% | 12.2% | 41.1% | 25.6% | 15.6% | 5.6% | 100.0% |
| 6 | Нийт | 2.4% | 14.1% | 39.8% | 28.0% | 8.6% | 7.3% | 100.0% |

Судалгаанд оролцогчдын орлогыг УИХ-аас баталсан хууль, тогтоол биелэгддэг байдлын үнэлгээтэй харьцуулж дээрх хүснэгтэд харууллаа. 2 сая төгрөгөөс дээш орлоготой иргэдийн 15.6 хувь нь УИХ-аас гаргасан хууль тогтоомж огт биелдэггүй гэж үзсэн нь өндөр үзүүлэлт болж байна.

Хүснэгт 20. УИХ-ын үйл ажиллагааны талаар үнэлгээ хөдөлмөр эрхлэлтийн байдлаар

| № | Хөдөлмөр эрхлэлт | Сайжирч байна | Хэвэндээ байна | Муудаж байна | Мэдэхгүй | Нийт |
|---|----------------------------------|---------------|----------------|--------------|----------|--------|
| 1 | Төрийн болон төсвийн байгууллага | 24.8% | 46.7% | 22.6% | 5.9% | 100.0% |
| 2 | Олон улсын байгууллага | 15.4% | 15.4% | 69.2% | 0.0% | 100.0% |
| 3 | Төрийн бус байгууллага | 20.8% | 31.3% | 41.7% | 6.3% | 100.0% |

“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтийн ойлголт, санаа бодол” судалгааны тайлан

| | | | | | | |
|----|---|-------|-------|-------|-------|--------|
| 4 | Хувийн байгууллага | 15.4% | 44.5% | 35.7% | 4.4% | 100.0% |
| 5 | Хувиараа бизнес эрхлэгч болон өрхийн бизнес эрхлэгч | 12.5% | 34.7% | 49.3% | 3.5% | 100.0% |
| 6 | Оюутан | 12.0% | 54.7% | 28.2% | 5.1% | 100.0% |
| 7 | ЕБС-ийн сурагч | 0.0% | 80.0% | 20.0% | 0.0% | 100.0% |
| 8 | Тэтгэвэрт | 28.2% | 40.9% | 27.8% | 3.2% | 100.0% |
| 9 | Группт | 13.0% | 39.1% | 34.8% | 13.0% | 100.0% |
| 10 | Малчин | 20.1% | 56.8% | 18.7% | 4.3% | 100.0% |
| 11 | Ажил эрхлэхгүй байгаа | 19.8% | 38.9% | 39.5% | 1.9% | 100.0% |
| 12 | Нийт | 20.4% | 43.9% | 31.2% | 4.6% | 100.0% |

График 13. Та УИХ-ын үйл ажиллагаанд хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?



Судалгаанд оролцогчид УИХ-ын үйл ажиллагаануудыг үнэлүүлэхэд ЗГ-т тавих хяналтыг хамгийн өндрөөр үнэлж 3-аас дээш оноо өгсөн нь бусад үнэлгээтэй харьцуулахад хамгийн өндөр нь болж байна. Иргэдийн хамгийн бага сэтгэл ханамжтай байгаа үнэлгээ нь УИХ дах сөрөг хүчний төлөөллийн ажлын үр дүн байна..

БҮЛЭГ 3. УИХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ХЭЛБЭР

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ. Мөн “Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна”⁴ гэж заасан нь хууль боловсруулах, санаачлах ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хангахтай холбоотой Үндсэн хуульд тодорхойлогдсон суурь зарчим юм.


Хуулийн төсөлд иргэдийн санал бодлыг тусгах, оролцоог нь хангах чиглэлд манай улсад дараах боломжит хэлбэрүүд хэрэгжиж байна. Үүнд:

- Хууль тогтоомжийн тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль

Эдгээр хуулиудад иргэдийн оролцоог хангах талаар зүйл заалтууд тусгагдсан бөгөөд иргэдийн оролцооны дараах боломжит хэлбэрүүд байна. Эдгээр нь хуулийн төслийн холбоотой нээлттэй сонголт хийх, иргэд УИХ-ын гишүүдэд буюу сонгосон төлөөлөгчдөдөө захидал бичих, уулзалт, зөвлөгөөн хэлэлцүүлэг зохион байгуулах, хувь хүмүүс болон, ТББ-ууд хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт оролцох, лобби, нөлөөллийн ажил зохион байгуулах зэрэг юм.

Харин судалгаанд оролцсон иргэдийн хувьд хуулийн төсөлд саналаа өгөх, хууль боловсруулах үйл ажиллагаанд оролцох боломжтой эсэх талаар 10 онооноос дунджаар 4.12 оноог өгсөн байна.

График 14 Иргэд хуулийн төсөлд саналаа өгөх, хууль боловсруулах үйл ажиллагаанд оролцох боломжтой байдал, насны бүлгээр




⁴ Монгол Улсын Үндсэн хууль

Насны ангиллаас хамаарч, иргэдийн хуулийн төсөлд оролцох саналаа өгөх боломжтой гэж үзэх итгэл нь буурч байна. Энэ нь гэрлэлтийн байдал, орлогын түвшин, амьдарч буй байршил, хүйс зэргээс хамаарч ямар нэгэн ялгаа үзүүлэхгүй байна.

График 15 Иргэдийн сонгосон төлөөлөгчидтэйгөө харьцаж буй оролцооны хэлбэрүүд

Судалгаанд оролцогчдын 2 хун тутмын нэг нь УИХ-ын гишүүдтэй огт харьцдаггүй байна. Иргэдийн хамгийн их ашигладаг суваг нь олон нийтийг хамарсан уулзалт цуглаан (26.7 хувь) байна. Харин судалгаанд хамрагдсан иргэдийн 1.3 хувь нь бүх хэлбэрээр УИХ-ын гишүүдтэй харьцаж чаддаг гэж хариулсан байна. Иргэдийн оролцооны хэлбэр нь хуулийн хүрээнд боломжтой хэдий ч бодит үйл ажиллагаа дээр хангалтгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.




Хүснэгт 21 Иргэдийн сонгосон төлөөлөгчидтэйгөө харьцаж буй оролцооны хэлбэрүүд, насны бүлгээр

| № | | 18 хүртэлх нас | 18-35 нас | 36-55 нас | 56- аас дээш нас |
|---|---------------------------------------|----------------|-----------|-----------|------------------|
| 1 | Шууд хэлбэрээр | 0.0% | 4.3% | 7.1% | 3.1% |
| 2 | Олон нийтийг хамарсан уулзалт цуглаан | 16.7% | 22.2% | 32.5% | 33.6% |
| 3 | Өргөдөл болон, захидлаар | 0.0% | 6.0% | 2.8% | 2.5% |
| 4 | Цахимаар | 16.7% | 13.9% | 11.1% | 4.4% |
| 5 | Дээрх бүгд | 0.0% | 1.2% | 2.0% | 0.0% |
| 6 | Бусад | 0.0% | 1.6% | 1.7% | 0.0% |
| 7 | Огт харилцдаггүй | 66.7% | 57.4% | 49.4% | 60.1% |

Судалгаанд оролцсон иргэдийн хувьд УИХ-ын гишүүдтэй харьцахдаа шууд хэлбэрээр буюу сонгогдсон төлөөлөгчидтэйгөө уулздаг гэж хариулсан байна. Энэ нь гишүүдийн тойрогтоо хийдэг уулзалтууд болон, бусад үйл ажиллагааны үеэр гишүүнтэй уулзах буюу тохиолдлын шинжтэй уулзалтууд болж байна. Харин 18 хүртэлх насныхны хувьд УИХ-ын гишүүдтэй огт харилцдаггүй гэж 66.7 хувь нь хариулсан байна. Судалгаанаас харахад энэ насныхан УИХ-ын үйл ажиллагаанд оролцох боломжтой байдаг талаарх мэдлэг ойлголт бусад насныхнаас бага зэрэг өндөр байдаг ч бодит оролцоо бага байна.

График 16 Иргэдийн сонгосон төлөөлөгчидтэйгөө харьцахыг хүсэж буй оролцооны хэлбэрүүд

Иргэдийн дийлэнх нь буюу 54.6 хувь нь УИХ-ын гишүүдтэй шууд хэлбэрээр харьцах (31.1 хувь) болон олон нийтийг хамарсан уулзалт цуглаанаар (23.5) дамжуулж гишүүдтэй харьцах сонирхолтой байна. УИХ-ын талаарх мэдээ мэдээлэл нь иргэдээс хэт хол байдаг болон сонгосон гишүүдтэйгээ уулзаж чаддаггүй тул иргэдийн хувьд гишүүдээс илүү иргэдтэй ойр ажиллах биечлэн уулзаж санал бодлыг нь сонсдог байх хэрэгтэй гэж үзэж байна.



Ярилцлагын хэсгээс

УИХ-ын гишүүдийг мэдээгээр л хардаг, ямар ажил хийж байгаа талаар мэдээлэл байдаггүй. Хөдөө орон нутагт хааяа ирдэг. Малчдын хувьд интернэт, facebook орох боломжгүй байдаг. Сар шинэ, баяр наадмаар ирж үзэгдээд зарим хөгшин настай улсад бэлэг тараагаад л ажил нь болж байгаа харагддаг. Нутаг орондоо ирж ард олонтойгоо уулздаг байвал сайн байна. Малчдын ахуй амьдралыг гишүүд мэдэх үү, мэдэхгүй. Иргэдийнхээ дунд орж ахуй амьдралтай нь танилцаж байж төрийн бодлого шийдвэр зөв байна гэж санагддаг юм. Алслагдсан аймгийн малчдад хурч ажилладаг байх хэрэгтэй.

Дорнод аймгийн харьяат, Малчин, 51 настай

Хүснэгт 22 Иргэдийн хувьд хуулийн төсөлд саналаа өгөх боломжууд, иргэдийн оршин суугаа бүсчлэлээр

| | | УИХ-ын гишүүд болон УИХ-д бичгээр (захидал) хандан саналаа хүргэх | УИХ-ын болон ИТХ-ын иргэдийг хүлээн авах байраар дамжуулах | УИХ-ын болон ИТХ-ын үйл ажиллагааг сурталчлах төвүүдэд хандан саналаа өгөх | УИХ-ын веб хуудас /Lawforum.parliament.mn/ руу орж саналаа өгөх | УИХ-ын гишүүний бие төлөөлөгчөөр дамжуулж саналаа өгөх | Бусад |
|---|-----------------|---|--|--|---|--|-------|
| 1 | Баруун бүс | 30.6% | 30.2% | 17.4% | 28.5% | 43.8% | 9.1% |
| 2 | Хангайн бүс | 26.4% | 30.3% | 13.0% | 40.5% | 34.9% | 9.5% |
| 3 | Төвийн бүс | 21.5% | 31.8% | 14.7% | 35.0% | 32.4% | 11.2% |
| 4 | Зүүн бүс | 22.0% | 33.0% | 21.4% | 39.0% | 35.7% | 10.4% |
| 5 | Улаанбаатар хот | 24.6% | 30.3% | 13.2% | 37.5% | 37.0% | 10.5% |

Судалгаанд оролцсон иргэдийн хувьд УИХ-ын хууль боловсруулах үйл ажиллагаанд оролцоходоо УИХ-ын веб хуудас /Lawforum.parliament.mn/ руу орж саналаа өгөх болон


УИХ-ын гишүүний бие төлөөлөгчөөр дамжуулж саналаа өгөх хэлбэрийг олонх нь дэмжиж байна.

Ярилцлагын хэсгээс

Сүүлийн жилүүдэд бараа, үнийн өсөлт арай хэтэрсэн. Хувиараа бизнес хийдэг бидний хувьд өөрсдийн амьдралыг өөрсдөө л авч явдаг. Тогтмол төрийн албаны цалин хөлс, тэтгэмж авдаггүй. Ийм үед үнэ хани өсөж хил гааль хаагдаад өвчин тахлын үед ч энэ төрийн бодлого буруу байна л гэж санагдах юм. Өөрсдийн нь амьдралд санаа зовох зүйл бага л байдаг байх. Бухимдах юм л их гарах юм. Ард түмний амьдрал яаж байна гэж ганц ирж танилцаж мэдэж байгаа зүйлгүй, ирэхдээ дарга даамал, захиргааныхантай уулзаад л явдаг, хурал хийж харагддаг. Харагддаг ч гэж мэдээгээр л гараад өнгөрдөг. Сонгуулиас бусад үед жирийн ард иргэдийг төлөөлж чадахгүй байна гэж хэлмээр байна. Цахимаар бичээд коммент сэтгэгдэлд ямар ч хариу байдаггүй. Манай эндхийн хүмүүс УИХ-ын гишүүдтэй бараг уулздаггүй болохоор саналаа бараг хэлж чаддаггүй, цахим орчинд саналаа илэрхийлсэн ч үр дүнгүй байдаг.

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, 42 настай эмэгтэй

График 17 Судалгаанд оролцсон иргэдийн lawforum.parliament.mn сайтыг хэрэглэдэг байдал



Судалгаанд оролцсон иргэдийн 76.9 хувь нь хуулийн төсөлд иргэдээс санал авах зориулалттай www.lawforum.parliament.mn сайтыг огт хэрэглэж үзээгүй, мэдэхгүй байна. www.lawforum.parliament.mn -аар байнга үйлчлүүлдэг гэж 1.4 хувь хариулсан байна. УИХ-ын үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог цахимаар хангахад чиглэсэн www.lawforum.parliament.mn сайт барьсан хуулийн төслүүд нь олон нийтэд бага танигдсан.

Иргэдийн оролцоог хангахад цахим орчныг ашиглах нь давуу талтай боловч иргэдийн цахимаар илэрхийлсэн санал хүсэлт, байр суурийг хүлээж авч ямар үр дүнд хүрсэн талаар хариу тайлагнах үйл явцыг орхигдуулах нь цахим оролцооны хувилбарын үр нөлөөг бууруулж байна.

ДҮГНЭЛТ

Мэдлэг, ойлголт

- Судалгаанд оролцогчдын гурван хүн тутмын нэг нь буюу 36.6 хувь нь УИХ-ын үйл ажиллагааны талаар сонирхдог
- УИХ-ын мэдээ мэдээллийг олон нийтэд цахимаар хүргэх, иргэдийн цахим оролцоог хангах ажлыг илүү олон нийтэд таниулах шаардлагатай байна. Тухалбал, судалгаанд оролцогчдын 93.2 хувь нь УИХ-ын албан ёсны веб сайт болох www.parliament.mn ийн талаар мэдэхгүй байна..
- УИХ-аар хэлэлцэж буй хуулийн төсөлд иргэдээс санал авах lawforum.parliament.mn веб сайт олон нийтэд танигдаагүй, хараахан хэрэглээ болж чадаагүй байна. Судалгаанд оролцсон иргэдийн 76.9 хувь нь уг талбарыг огт мэдэхгүй болон ашиглаж байгаагүй.
- Иргэд УИХ-ын үйл ажиллагааны талаар сонирхох байдал хөдөлмөр эрхлэлтийн байдлаасаа хамаарч төрийн албан хаагчид, малчид, групп тогтоолгосон иргэдийн хувьд илүү өндөр байна.
- Иргэдийн УИХ-ын үйл ажиллагаанд оролцох боломжийг 10 оноогоор үнэлүүлэхэд дунджаар 4.12 оноог өгсөн.
- Нийт судалгаанд оролцогчдын 57.35 хувь нь хууль санаачлах, 57.6 хувь нь хууль батлах үйл ажиллагааг УИХ-ын үндсэн чиг үүрэгт хамаарна гэж хариулсан. 46.75 хувь нь Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, 43.1 хувь нь ЗГ-ын үйл ажиллагаанд хяналт тавих, 43 хувь нь төсөв батлах ажил нь УИХ-ын үндсэн чиг үүрэгт хамаарна гэж үзсэн байна.
- Иргэдийн боловсролын түвшнээс хамаарч УИХ-ын чиг үүргүүдийн талаарх мэдлэг ойлголт нь ялгаатай байна. Иргэд хууль санаачлах хууль батлах гэсэн 2 чиг үүргийг мэддэг боловч төсөв батлах, хуулийн хэрэгжилтэй хяналт тавих, хянан шалгах зэрэг бусад чиг үүргүүдийн талаар мэдлэг ойлголт хангалтгүй байна.

Санаа бодол, Үнэлгээ

- Судалгаанд оролцсон иргэд УИХ-ын гишүүдийн хариуцлагыг 10 онооноос 4.22, УИХ-ын үйл ажиллагаанд өгөх сэтгэл ханамжийн үнэлгээг 10 онооноос 4.56 оноогоор үнэлсэн.
- Судалгаанд оролцогчдын 20.4 хувь нь УИХ-ын үйл ажиллагааг сайжирч байна, 43.9 хувь нь хэвэндээ, 31.3 хувь нь муудаж байна гэж үнэлжээ. Насны бүлгээр харьцуулан үзвэл УИХ-ын үйл ажиллагаанд 56-аас дээш насныхан илүү өндөр үнэлгээ, 18-35 насны залуучууд доогуур үнэлгээ өгч байна.
- УИХ-ын үйл ажиллагаанд өгөх үнэлгээ, сэтгэл ханамж хүйсийн хувьд төдийлөн ялгаагүй байна.
- Судалгаанд оролцсон иргэд УИХ-ын гишүүдийн хариуцлагыг 10 онооноос 4.21 оноогоор үнэлсэн.
- УИХ-ын үйл ажиллагааг 1-5 оноогоор үнэлүүлэхэд; гишүүд хууль санаачлах эрхээ үр нөлөөтэй гүйцэтгэдэг байдал 2.66, УИХ-нь хүний эрх эрх чөлөөг хамгаалах, хангах чиглэлд анхаарч ажилладаг 2.59, УИХ-нь Засгийн газарт

хяналт тавьж ажиллаж чаддаг 3.11, УИХ-нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж чаддаг, УИХ дахь сөрөг хүчний төлөөллүүд үр дүнтэй ажиллаж чаддаг байдал 2.45 оноо тус тус авсан.

- УИХ-ын үйл ажиллагааны хүртээмжтэй байдлыг 1-5 оноогоор үнэлүүлэхэд: өргөдөл гомдол шийдвэрлэх журмын хэрэгжилт, хариу өгдөг байдал 2.7, УИХ-ын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал 2.9, мэдээллийн ил тод байдал 2.69, иргэдэд ээлтэй , хялбар байдал 2.5, баримт бичгийн хүртээмжтэй байдал 2.68 оноогоор тус бүр үнэлжээ.
- УИХ-аас баталсан хууль, тогтоол үргэлж биелдэг гэж судалгаанд оролцогчдын зөвхөн 2.4 хувь нь хариулсан бол ихэвчлэн 14.1, заримдаа 39.8, хааяа 28, огт биелэгддэггүй гэж 8.6 хувь нь үзэж байна.
- УИХ-ын үйл ажиллагааг Улаанбаатараас илүү хөдөө орон нутгийн иргэд өндрөөр үнэлж байна. 10 онооноос Улаанбаатарт 4.29 оноо, орон нутагт 4.8 оноо өгчээ. Төвөөс алслагдах тусам үнэлгээ өсөж, төврүү ойртох тусам УИХ-ын үйл ажиллагаанд өгөх үнэлгээ буурч байна.

Оролцоо

- Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах боломжууд болон эрх зүйн орчны талаар иргэдэд мэдлэг ойлголт бага байна.
- Иргэдийн хувьд УИХ-ын үйл ажиллагаанд оролцох боломжтой гэсэн төсөөлөлтэй боловч бодит оролцоо хангалтгүй түвшинд байна. Судалгаанд оролцсон 2 хүн тутмын нэг нь сонгосон төлөөлөгчтэйгөө огт харилцаа холбоогүй байна.
- Иргэдийн дийлэнх нь буюу 54.6 хувь нь УИХ-ын гишүүдтэй шууд хэлбэрээр харьцах (31.1 хувь) болон олон нийтийг хамарсан уулзалт цуглаанаар (23.5) дамжуулж гишүүдтэй харьцах сонирхолтой байна.
- Судалгаанд оролцогчдын нас ахих тусам УИХ-ын үйл ажиллагаанд оролцох боломжийг бага гэж үзэж байна. 10 онооноос 18-35 насныхан 4.27, 36-55 насныхан 4.01, 56-аас дээш насныхан 4.03 оноо өгчээ.
- Сонгогдсон төлөөлөгчидтэйгөө биечлэн уулзах болон бие төлөөлөгчөөр нь дамжуулж санаа бодлоо илэрхийлдэг байхыг иргэд хүсэж байна.
- Иргэдийн оролцоог хангахад цахим орчныг ашиглах нь давуу талтай боловч иргэдийн цахимаар илэрхийлсэн санал хүсэлт, байр суурийг хүлээж авч ямар үр дүнд хүрсэн талаар хариу тайлагнах үйл явцыг орхигдуулах нь цахим оролцооны хувилбарын үр нөлөөг бууруулж байна.
- УИХ-ын үйл ажиллагаанд дахь иргэдийн оролцооны хэлбэрийг сайжруулахын тулд УИХ-ын үйл ажиллагаа, чиг үүргийг иргэдэд таниулах, парламентын боловсролыг нэмэгдүүлэх хэрэгцээтэй нь судалгааны үр дүнд харагдаж байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

- УИХ-ын үйл ажиллагаа, хууль тогтоох процессыг иргэдэд таниулах, УИХ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд Нэгдүгээрт. Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, Хоёрдугаарт. Иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, Гуравдугаарт. УИХ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцооны сувгуудыг дэмжих нь оновчтой.

Мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд

- Мэдээллийн ил тод байдал нь цахимд суурилна. Хэн ч хэзээ ч хаанаас ч хандаж мэдээлэл авах боломжтой нь цахим талбарын давуу тал юм. Цахим нээлттэй мэдээлэл нь зөвхөн иргэд сонгогчид бус судлаач мэргэжилтнүүд, сэтгүүлчдийн мэдээллийн анхдагч эх сурвалж болж тэднээр дамжих илүү олон хүнд хүрэх боломжтой.
- www.parliament.mn веб сайтын бүтэц үйл ажиллагаа сайжруулах. Одоогийн сайтын бүтэц нь УИХТГ-ын бүтцийг цахимд буулгах байдлаар хэлбэржүүлсэн байгааг хялбарчлан, иргэд сонгогчдын хувьд мэдээлэл авахад хялбар энгийн бүтэцтэй болгох нь зүйтэй.
- Хэдийгээр УИХ-нь сонгуулиар, 18 насанд хүрсэн сонгогчдын саналаар бүрддэг ч УИХ-аас батлан гаргасан хууль тогтоомж нь улс даяар, нийт хүн амд хүрч хэрэгждэг тул парламентын мэдээллийг хэрэглэгчдийг монгол улсын нийт хүн ам гэж үзэх нь зохистой.
- Албан ёсны веб сайт нь нийт иргэд, сонгогчдод зориулсан албан ёсны талбар болохын хувьд иргэдийн олон талт байдал, нийгмийн бүлгүүд, тэдний ялгаатай байдлыг харгалзан үзсэн олон талт байх нь зүйтэй. Иргэд сайтаар зочлохдоо сонголт хийж өөрсдийн нас, онцлогт тааруулах боломжтой байх нь хүртээмжийг нэмэгдүүлнэ. Жишээлбэл хялбарчилсан болон энгийн, насанд хүрэгсэд болон хүүхдэд өсвөр үеийнхэнд зориулсан байдлаар парламентын мэдээллийг хүргэх.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг хүртээмжтэй хүргэх. УИХ-аас гарч байгаа албан ёсны мэдээллүүдийг веб сайтдаа нийтлэхдээ харааны бэрхшээлтэй хүн сонсох боломжтой аудио хавсаргах, видео мэдээллийг дохионы хэлмэрчтэй болгох.
- Мэдээллийн ил тод байдлын хувьд хуулийн төсөл бүрийн мэдээллийг нэг дороос бүрэн авах боломжтой болгох. Үүнд: хуулийн төслийг санаачилсан, ажлын хэсэгт ажилласан гишүүд баг бүрэлдэхүүний танилцуулга мэдээлэл, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, хуулийн төслийг хэлэлцэх хуралдааны товууд, хуралдаануудаар өөрчлөгдсөн саналууд, тухайн хуулийг хэлэлцсэн байнгын хороо болон чуулганы тэмдэглэлүүд, хуулийн төслийг эцэслэн батлахад гишүүдийн өгсөн санал болон бусад мэдээлэл багтана.
- УИХ-ын гишүүдийн ирцийн мэдээлэл, хуулийн төсөлд өгсөн санал, санаачилсан, ажлын хэсэгт нь ажилласан хууль зэрэг мэдээллийг гишүүн тус бүрээр харах боломжтой болгох.

- УИХ-ын чуулганы хуралдаан болон байнгын хорооны хурлуудын бичлэгийг нэгдсэн байдлаар он цагийн дараалал, болон хэлэлцсэн асуудлаар шүүж үздэг болгох.
- УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан болон, байнгын хороо, намын бүлгүүдийн хуралдаан зэрэг нийт хуралдааны товгыг нэгдсэн календарьд багцалж албан ёсны веб сайтад байрлуулах.

Иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх

- УИХ-ын гүйцэтгэх үндсэн чиг үүргийг таниулах. Хууль тогтоох үйл явц шат дараалал, үүнд иргэдийн оролцох боломжийг маш тодорхой, хүртээмжтэйгээр иргэдэд таниулах. УИХ-ын хянах шалгах, төсөв хэлэлцэх, батлах чиг үүргийг сурталчлах.
- УИХ юу хийдэггүйг онцлон таниулах. Иргэдийн хувьд УИХ-ын гишүүдээс шаардвал зохих үүргийг мэддэг байх нь гишүүдээс чиг үүрэгт нь хамааралгүй зүйл нэхэх, түүнээс улбаалан ажил цалгардах, цаашилбал нийт засаглалын системд эрх мэдлийн тэнцвэрийг хадгалахад нийгмийн хүчин зүйлийн хувьд чухал дэмжлэг болно.
- Өмнөх бүлэг зөвлөмжид дурдсаны дагуу нээлттэй мэдээллийн эх үүсвэр нь парламентын боловсролыг дэмжих суурь болно. Иймд www.parliament.mn веб сайтын мэдээллийг нээлттэй байдал, хүртээмжийг сайжруулах.
- УИХ-ын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх нь иргэдийн боловсролыг дэмжих гол дэмжлэг болох бөгөөд мэдээллийн чанар, агуулга их байх тусам энэ боломж нэмэгдэнэ.
- Хөдөө орон нутаг болон алслагдсан сум, багт байгаа иргэдийн улс төрийн боловсролыг нэмэгдүүлэхэд чиглэсэн тусгайлсан хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.
- ЕБС, МСҮТ-ийн суралцагч, их дээд сургуулийн оюутнуудын дунд тэдний сонирхдог сэдэв, үйл ажиллагаатай уялдуулах байдлаар УИХ-ын үйл ажиллагааг сурталчлах. Жишээлбэл сурагч, оюутнуудын дунд УИХ-аар хэлэлцэж буй сэдвийн хүрээнд Парламентын мэтгэлцээний тэмцээн зохион байгуулах.

Иргэдийн оролцоог дэмжих

- УИХ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжтой хэлбэрүүдийг олон нийтэд таниулах.
- www.parliament.mn албан ёсны сайтыг онцгойлон сурталчлах. Уг сайтыг мэддэг хэрэглэгч судалгаанд оролцогчдын дунд 6.2 хувь буюу тун хангалтгүй байсан.
- www.lawforum.parliament.mn талбарыг иргэдэд таниулж хэрэглээг дэмжих. Хуулийн төслүүдэд иргэдээс санал авах уг талбарт зөвхөн УИХ-ын гишүүдийн өргөн барьсан хуулиас гадна, ЗГ, Ерөнхийлөгчөөс санаачилж буй хуулийн төслүүдийн оруулж санал авах боломжтой болгох. Уг талбарт санал гаргасан иргэдэд заавал хариу өгч байх.
- Иргэдийн оролцоо санал хүсэлтэд тогтмол хариу өгч, эргэх холбоог дэмжих. Иргэдийн өгсөн санал хүсэлт, оролцоонд хариу өгөхгүй байх нь тэдний оролцоог хязгаарлах, оролцооны үр дүнг унагах гол шалтгаан болж байна.
- Иргэдээс ирсэн өргөд гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх, хариу өгөх боломжийг албан ёсны веб сайтад нэмэх. Иргэдийн хувьд санал хүсэлт


хүргүүлсэн ч тодорхой хариу авч чаддаггүй гэх гомдол судалгааны явцад нийтлэг гарч байсан.

- УИХ-ын гишүүдийн ажлын явцыг иргэдэд тодорхой мэдээлдэг байх. Тухайлбал: Иргэд сонгосон гишүүнийхээ ямар ажил хийсэн болон хийж байгаа талаар мэдээллийг нэгдсэн эх сурвалжаас авч чадахгүй байгааг нийтлэг илэрхийлж байсан.
- УИХ-ын хэлэлцэн баталсан хууль тогтоомжуудын хэрэгжилтэд тогтмол үнэлгээ хийх, олон нийтэд тайлагнах. Ил тод байдал, тайлагнах, иргэдийг тогтмол мэдээллээр хангах тэдний оролцоог дэмжих гол суурь болно.

ХАВСРАЛТ

Иргэд орон нутгийн хурлын хамтын ажиллагаа


Бэлчээрийн асуудлаар иргэд орон нутгийн хуралтай хамтран ажилладаг эсэх



Нүүдлийн мал аж ахуй зонхилсон хөдөө аж ахуйн нийгэм нь манай орны нийгмийн бүтцэд чухал байр суурь эзэлдэг. Тиймээс тэдгээр иргэдэд чиглэсэн зөв зүйтэй бодлого үйл ажиллагааг явуулах нь бүх шатны төрийн байгууллагын чухал үүрэг болдог. Тэдгээрийн нэг нь малчдын нийгэм, эдийн засгийн баталгаатай шууд холбогдох бэлчээрийн асуудал юм. Тиймээс орон нутгийн иргэдийн хурлын байгууллага уг асуудлаар иргэдтэй хамтран ажилладаг талаарх асуултад судалгаанд оролцогчдын

27.6% нь тийм гэж хариулсан бол мөн ойролцоо тооны оролцогчид үгүй гэж хариулсан байна. Харин хамгийн олон оролцогчид буюу 42.9% нь энэ талаар огт мэдэхгүй гэж хариулсан байна.


Бэлчээрийн асуудлаар орон нутгийн байгууллага иргэдийн хамтын ажиллагааны хэлбэрүүд



Бэлчээрийн асуудлаар орон нутгийн иргэдийн хурал иргэдтэйгээ хамтран ажилладаг гэж үзсэн оролцогчдоос хэрхэн хамтран ажилладаг талаар нэмж тодрууллаа. Тэдгээрийн 48.9% нь орон нутгийн хурлаас иргэдэд мэдээлэл өгдөг гэж үзсэн бол 27.3% нь хэлэлцүүлэг, сургалтад хамруулдаг гэж хариулсан байна. Харин хамгийн цөөн хувь нь буюу 2.9% нь багийн хурал дээр хэлэлцдэг гэж үзжээ.


Бэлчээрийн асуудлаар иргэд орон нутгийн хамтын ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг эсэхийг 1-10 оноогоор үнэлүүлэхэд судалгаанд оролцогчид дунджаар 4.78 оноогоор үнэлсэн байна.

Бэлчээрийн асуудлаар иргэд орон нутгийн хуралтай хамтран ажилладаг эсэх, хүйсээр



Судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн хувьд иргэд бэлчээрийн асуудлаар орон нутгийн хуралтай хамтарч ажилладаг гэж 31.6 хувь нь үзэж байгаа бол эмэгтэйчүүдийн 24 хувь нь иргэд бэлчээрийн асуудлаар орон нутгийн хуралтай хамтарч ажилладаг гэж үзэж байна. Харин иргэд бэлчээрийн асуудлаар орон нутгийн хуралтай хамтарч ажилладаг талаар судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 39.5 хувь, эмэгтэйчүүдийн 45.8 хувь нь ямар нэгэн мэдээлэлгүй байна.

Бэлчээрийн асуудлаар иргэд орон нутгийн хуралтай хамтран ажилладаг эсэх, оршин суугаа бүс нутгаар



Зүүн бүсийн оршин суугчдын хувьд бэлчээрийн асуудлаар орон нутгийн хуралтай хамтран ажилладаг гэж 42.9 хувь нь хариулсан нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн их хамтын ажиллагаатай байна. Хангайн бүсийн оршин суугчдын хувьд иргэд бэлчээрийн асуудлаар орон нутгийн хуралтай хамтарч ажилладаг талаар мэдэхгүй гэж 38 хувь нь хариулсан нь хамгийн өндөр хувь болж байна.

Бэлчээрийн асуудлаар иргэд орон нутгийн хуралтай хамтран ажилладаг эсэх, гэр бүлийн байдлаар

| № | | Гэрлэсэн | Гэрлээгүй | Өрх толгойлсон | Бэлэвсэн |
|---|----------|----------|-----------|----------------|----------|
| 1 | Тийм | 30.1% | 19.5% | 29.0% | 9.8% |
| 2 | Үгүй | 30.2% | 24.3% | 28.0% | 56.1% |
| 3 | Мэдэхгүй | 39.7% | 56.3% | 43.0% | 34.1% |


“Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх иргэд олон нийтийн ойлголт, санаа бодол” судалгааны тайлан

Бэлчээрийн асуудлаар орон нутгийн байгууллага иргэдийн хамтын ажиллагааны хэлбэрүүд, оршин суугаа бүс нутгаар



Иргэдийн бэлчээрийн асуудлаар орон нутагтай хамтарч ажилладаг гэж үзэж буй хэлбэр нь ихэвчлэн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр болон цахимаар мэдээлэл авдаг хэлбэр байна. Иргэд орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааны хэлбэрүүдээс хамгийн бага санал авсан нь багийн хуралд очиж шууд уулзалтууд хийх болон техник, материаллаг баазаар хангагддаг гэсэн хувилбарууд байна.

Бэлчээрийн асуудлаар иргэд орон нутгийн хамтын ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг эсэх, оршин суугаа бүс нутгаар



Судалгаанд хамрагдсан иргэд бэлчээрийн асуудлаар орон нутгийн хуралтай хамтын ажиллагааны нөхцөл байдлыг дээрх байдлаар үнэлж байна.